

Хүснэгт 5.2.5 Дорноговь аймгийн нутгийн тогтвортой усжуулалттай бэлчээр дэх даацын баланс


3 км-ийн дотор	Хүчин чадал (Хоньд шилжүүлснээр)	Уст цэгээс 3 км-ээс дотогш хүрээнд байх малын тоо					
		1999			2002		
		Малын тоо	Хонин толгойгоор	Тэнцвэр(%)	Малын тоо	Хонин толгойгоор	Тэнцвэр(%)
Айраг	83 599	58 782	96 624	115,6	53 261	75 037	89,8
Алтанширээ	74 898	58 781	98 340	131,3	38 429	58 957	78,7
Даланжаргалан	81 769	85 521	151 581	185,4	50 236	74 541	91,2
Дэлгэрэх	90 706	89 679	171 160	188,7	52 279	91 890	101,3
Эрдэнэ	121 410	72 387	124 774	102,8	52 665	76 720	63,2
Иххэт	67 027	58 831	106 228	158,5	39 076	60 696	90,8
Хатанбулаг	124 770	122 012	190 668	152,8	91 962	121 844	97,7
Хөвсгөл	121 190	78 593	131 547	108,5	51 930	76 575	63,2
Мандах	105 443	69 406	108 180	100,7	66 484	90 987	86,3
Сайхандулаан	108 987	56 287	88 394	81,1	62 399	88 811	81,5
Сайншанд	22 241	52 725	68 238	306,8	55 299	65 378	294,0
Улаанбадрах	135 240	84 689	124 360	92,0	63 292	79 833	59,0
Өргөн	99 563	68 091	104 999	105,5	52 186	73 246	73,6
Замын Үүд	4 306	7 602	8 635	200,5	4 985	5 150	119,6
Нийт	1 241 147	963 586	1 571 728	-	734 483	1 039 665	-
Нийт (дундаж)*	1 214 601	903 059	1 494 855	123,1	674 199	969 137	79,8
3-5 км-ийн дотор	Хүчин чадал (Хоньд шилжүүлснээр)	Уст цэгээс 3-5 км-ийн хүрээнд байх малын тоо, 3 км-ийн хүрээг хассан.					
		1999			2002		
		Малын тоо	Хонин толгойгоор	Тэнцвэр(%)	Малын тоо	Хонин толгойгоор	Тэнцвэр(%)
Айраг	36 786	9 472	56 206	152,9	5 851	34 488	93,8
Алтанширээ	35 703	9 186	54 542	152,8	5 085	29 911	83,8
Даланжаргалан	19 913	7 729	46 051	231,3	3 056	18 084	90,8
Дэлгэрэх	20 029	7 422	44 184	220,6	3 759	22 219	110,9
Эрдэнэ	45 782	11 516	67 936	148,4	5 582	32 393	70,8
Иххэт	19 114	6 079	36 306	189,9	2 934	17 478	91,4
Хатанбулаг	123 950	15 210	88 280	71,2	7 242	41 112	33,2
Хөвсгөл	39 760	8 065	46 982	118,2	3 992	22 594	56,8
Мандах	50 966	9 701	55 634	109,2	6 900	38 999	76,5
Сайхандулаан	47 574	8 246	48 158	101,2	7 048	40 923	86,0
Сайншанд	14 127	8 337	48 978	346,7	6 029	34 842	246,6
Улаанбадрах	62 683	11 306	65 819	105,0	5 155	29 211	46,6
Өргөн	48 792	10 558	62 602	128,3	6 413	37 721	77,3
Замын Үүд	3 241	2 611	15 536	479,4	643	3 705	114,3
Нийт	568 400	125 438	737 212	-	69 689	403 680	-
Нийт (дундаж)*	551 032	114 490	672 698	122,1	63 017	365 133	66,3
5 км-ийн дотор	Хүчин чадал (Хоньд шилжүүлснээр)	Уст цэгээс 5 км-ээс дотогш хүрээнд байх малын тоо					
		1999			2002		
		Малын тоо	Хонин толгойгоор	Тэнцвэр(%)	Малын тоо	Хонин толгойгоор	Тэнцвэр(%)
Айраг	120 365	68 254	152 830	127,0	59 112	109 525	91,0
Алтанширээ	110 601	67 967	162 882	138,2	43 514	88 868	80,4
Даланжаргалан	101 682	93 250	197 632	194,4	53 292	92 625	91,1
Дэлгэрэх	110 735	97 101	215 344	194,5	56 038	114 109	103,0
Эрдэнэ	167 192	83 903	192 710	115,3	58 247	109 113	65,3
Иххэт	86 141	64 910	142 534	165,5	42 010	78 174	90,8
Хатанбулаг	248 720	137 222	278 948	112,2	99 204	162 958	65,5
Хөвсгөл	180 950	86 658	178 529	110,9	55 922	99 169	61,6
Мандах	156 409	79 107	161 814	103,5	73 384	129 986	83,1
Сайхандулаан	156 561	64 533	136 550	87,2	69 447	129 734	82,9
Сайншанд	36 368	61 062	117 216	322,3	61 328	100 220	275,6
Улаанбадрах	197 923	95 995	190 179	96,1	68 447	109 044	55,1
Өргөн	148 355	78 649	167 601	113,0	58 599	110 967	74,8
Замын Үүд	7 547	10 213	24 171	320,3	5 628	8 855	117,3
Нийт	1 809 548	1 088 824	2 308 940	-	804 172	1 443 345	-
Нийт (дундаж)*	1 765 833	1 017 549	2 187 553	122,8	737 216	1 334 270	75,6

*Нийт дундажийг 12 сумын үзүүлэлтээр авав. Сайншанд ба Замын Үүдийг оруулаагүй.

Эх сурвалж : Цэрэндаш ба бусад, ЖАЙКА

4) Бэлчээрийн мониторингийн тогтолцоог бий болгохын ач холбогдол

Усжуулалтын хүчин чадал, малын тоо толгой, бэлчээрийн даацын харилцан хамаарлын зургийг доор харуулав. 5.2.4 дүгээр зурагт өнөөгийн нөхцөл байдал болон хойно өгүүлэх худаг байгуулалттай холбоотойгоор тавигдах бэлчээрийн менежментийн зорилт, мөн мал, бэлчээрийн менежментийн арга технологийн гүйцэтгэх үүргийг үзүүлэв.



Зураг 5.2.4 Усжуулалтын хүчин чадал, малын тоо толгой, болон бэлчээрийн даацын харилцан хамаарал

Өвөлжөө, хаваржааны хуучин гар худаг (өнөөгийн байдал) зэрэг уст цэгийн усалгааны хүчин чадал маш бага байх тохиолдолд мал сүрэг удаан хүлээгдсэнээр худгийн ойр орчмын бэлчээрийн тахлагдлыг улам хурдасгахад хүрнэ. Худгийн хүчин чадлыг нэмэгдүүлвэл услах малын тоо нэмэгдэх боловч худгийн ойролцоох бэлчээрийн даацыг сайжруулахад шууд хувь нэмэр үзүүлэхгүй. Иймд худгийн хүчин чадал өсөх нь бэлчээрийн хэт ашиглалтыг улам бүр нэмэгдүүлэх эрсдэлийг бий болгож болзошгүй юм. Харин мал услагааны зүй зохистой (малд хяналт тавих) аргыг хэрэглэх, сайжруулах замаар энэхүү эрсдэлийг сааруулж болно. Өөрөөр хэлбэл бэлчээр ашиглалт нь усжуулах байгууламж болон хүний хүчин зүйлийг нэгэн цогц болгосон усжуулалтын үр ашгийг сайжруулах үйл ажиллагаан дээр үндэслэн явагдах нь зүйтэй юм. "Өвөлжөө, хаваржааны услах байгууламжийг сайжруулах, шинээр бий болгох", "Бага ашиглалттай болон ашиглалтгүй бэлчээрт услах байгууламж байгуулах" зорилтод тусгагдсан

усжуулах байгууламжийг бий болгох материаллаг талын арга хэмжээтэй хамт дээр өгүүлсэн бэлчээрийн мониторингийн тогтолцоог бий болгох зэрэг оюунлаг талын үйл ажиллагааг эрчимтэй явуулах нь ихээхэн ач холбогдолтой.

(3) Бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг худаг байгуулалттай холбоотойгоор авч үзэх шаардлага

Худаг байгуулалтад чиглэсэн бэлчээрийн менежментийн төлөвлөгөө нь өвөлжөө, хаваржааны орчинг сайжруулах, бага ашиглалттай ба ашиглалтгүй бэлчээрийг эзэмших гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Хэсэг тус бүрд материаллаг ба оюунлаг тал дээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахи байдлаар дараахь хүснэгтэд тоймлон харуулав.

Хүснэгт 5.2.6 Уст цэг байгуулах, сайжруулах үйл ажиллагаа ба бэлчээрийн менежмент

	Услах байгууламж(материаллаг тал)	Бэлчээр ашиглалт (оюунлаг тал)
Өвөлжөө, хаваржааны орчинг сайжруулах	Өвөлжөө хаваржааны услах байгууламжийг сайжруулах, шинээр бий болгох (онгоц)	Гар худгийн ойр орчмын бэлчээрийн ашиглалтыг сайжруулах(худаг ашиглалтын журам)
Бага ашиглалттай, ашиглалтгүй бэлчээрийг эзэмших	Зуслан, намаржааны ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрт усжуулах байгууламж байгуулах (худаг, онгоц, усан сан)	Өрөмдмөл худаг, богино яндант худгийн ашиглалтын арга технологийг сайжруулах

Тэрчлэн "Өвөлжөө, хаваржааны орчинг сайжруулах төлөвлөгөө", "Бага ашиглалттай ба ашиглалтгүй бэлчээрийг эзэмших төлөвлөгөөг" хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь байдлаар тоймлон авч үзэж болно.

Хүснэгт 5.2.7 2 төрлийн уст цэгийг байгуулах болон бэлчээрийн менежментийн үйл ажиллагаа

	Өвөлжөө, хаваржааны орчинг сайжруулах	Бага ашиглалттай ба ашиглалтгүй бэлчээрийг эзэмших
Үр дүн	<ul style="list-style-type: none"> • Усжуулах чадавхи сайжрах • Усалгааны арга технологи сайжрах • Мал өвөлжих байгууламж сайжрах 	<ul style="list-style-type: none"> • Отор нүүдлийн бэлчээрийн талбай нэмэгдэх • Усжуулах чадавхи сайжрах • Усалгааны арга технологи сайжрах
Үйл ажиллагаа	<ul style="list-style-type: none"> • Гар худгийг засварлах • Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах • Өвөлжөө, хаваржааны услах байгууламжийг сайжруулах • Усалгааны цагийг зохицуулах, дараалал тогтоох • Малчдын бүлэг байгуулах 	<ul style="list-style-type: none"> • Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах • Усалгааны туслах байгууламжийг сайжруулах • Малчдын бүлэг байгуулах

Өвөлжөө, хаваржааны орчныг сайжруулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь малын хашаа хороо, өвс тэжээлийн агуулах, саравчийг засварлахаас гадна гар худгийг үр бүтээлтэй ашиглах арга замыг эрэлхийлэх, мал услах цагийг зохицуулах, усалгааны дараалал тогтоох зэрэг худаг

ашиглалтын журмыг бий болгоход чиглэнэ. Малчид өөрсдийн хүч боломжоор хуучин худгийг засварлах, шинээр худаг гаргах зэрэг усжуулалтын нөхцөл байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг хамтран хэрэгжүүлж болно. Ингэснээр мал усалгааны цаг хэмнэгдэж, усалгааны үр ашиг дээшилнэ.

1) Өвөлжөө, хаваржааны орчныг сайжруулах төлөвлөгөө

Малчдын бүлэг, төв, орон нутгийн засаг захиргаа болон хандивлагчдын зүгээс авч хэрэгжүүлэх арга хэмжээг 5.2.8 дугаар хүснэгтэд тоймлон харуулав.

Хүснэгт 5.2.8 Өвөлжөө хаваржааны орчинг сайжруулах төлөвлөгөө

	Үйл ажиллагааны чиглэл	Малчдын бүлгийн үйл ажиллагаа	Сум, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаа	Улс, хандивлагчдын үйл ажиллагаа
1	Гар худаг засварлах	<ul style="list-style-type: none"> Гар худаг, бетон хашлагат худаг засварлахад шаардлагатай хүн хүч гаргах 		<ul style="list-style-type: none"> Гар худаг, уурхайн худаг засварлахад шаардлагатай материал, ачааны машин гаргах
2	Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах	<ul style="list-style-type: none"> Малчдын бүлэг байгуулах, худгийн арчилгааг хариуцах 	<ul style="list-style-type: none"> Малчдын бүлэг байгуулах 	<ul style="list-style-type: none"> Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах
3	Усалгааны цагийг зохицуулах, дараалал тогтоох	<ul style="list-style-type: none"> Худаг ашиглалтын журам (усалгааны цагийг зохицуулах) гаргаж хэрэгжүүлэх 	<ul style="list-style-type: none"> Худаг ашиглалтын журамд зохицуулалт хийх, хяналт тавих 	<ul style="list-style-type: none"> Худаг ашиглалтын журмыг нэвтрүүлэх ажлыг зааварчлан чиглүүлэх
4	Өвөлжөө, хаваржааны байгууламжийг сайжруулах	<ul style="list-style-type: none"> Малын хашаа хороо засах Өвс, тэжээлийн агуулах, саравч барих 		

i) Гар худаг засварлах, шинээр гаргах

Өвөлжөө, хаваржааны орчинг сайжруулах төлөвлөгөөний хүрээнд гар худгийн ажлыг өрнүүлнэ. Гар худаг нь хамгийн түгээмэл, монголын нүүдлийн мал аж ахуйг тэтгэж ирсэн, уламжлалт хэлбэр хийцтэй худаг болно. Иймд малчид гар худаг гаргах төдийгүй түүнийг арчилж, хамгаалахад идэвхи, санаачлагатай оролцох ёстой юм. Мөн засаг захиргааны зүгээс бэлчээрийн ашиглалтыг сайжруулахын тулд усалгааны үр ашгийг дээшлүүлэх шаардлагын үүднээс малчид өөрсдийн санаачлагаар худаг гаргах үйл ажиллагаа, сонирхлыг хөхүүлэн дэмжих нь маш чухал юм.

ii) Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах

Өвөлжөө, хаваржааны хуучин гар худгийн усжуулалтын бүтээмж нь 0.1л/с байх үед 1 цагт услах малын тоог дараахь хүснэгтэд харуулав. Зун, намарт 70 толгойгоос доош, өвөл хаварт 120 толгойгоос доош, жилд дунджаар 90 толгой орчим байна.

Хүснэгт 5.2.9 Усжуулалтын бүтээмж ба 1 цагт услах боломжтой малын тоо

	Дундаж үзүүлэлт (л/с)	1 цагт услах малын тоо (х.т.*)		
		Зун-намар	Өвөл-хавар	Дундаж
Өндөр	0.5<	360<	600<	450<
Дунд зэрэг	<0.1-0.5<	<70-360<	<120-600<	<90-450<
Бага	<0.1	<70	<120	<90

*х.т.=хонин толгой : 1хоньд ногдох бэлчээрийн даац

Мөн усжуулалтын бүтээмж 0.1л/с –с бага байх үеийн үзүүлэлтийг авч үзэж болох юм. 5.2.10 дугаар хүснэгтэд үзэхэд хонин толгойд шилжүүлснээр 200-300 толгой малтай суурийг услахад 2.5 цаг, 500-600 малтай суурийг услахад 5 цагаас дээш, 800-1000 малтай суурийг услахад 8 цагаас дээш хугацаа шаардагдах тооцоо гарч байна.

Хүснэгт 5.2.10 Усжуулалтын бүтээмж болон малын тоо тус бүрээр услагаанд шаардагдах цагийн харилцан хамаарал

	Дундаж үзүүлэлт (л/с)	Малын тоо (х.т.)		
		200-300	500-600	800-1,000
Өндөр	0.5<	<0.5цаг	<1цаг	<2 цаг
Дунд зэрэг	<0.1-0.5<	<0.5-2.5цаг <	<1-5 цаг <	<2- 8цаг <
Бага	<0.1	2.5цаг <	5 цаг <	8 цаг <

Өрөмдмөл худгийг засварлах, шинээр гаргах ажлыг хэрэгжүүлэхдээ бага ашиглалттай ба ашиглалтгүй бэлчээр эзэмших асуудлыг нэн тэргүүнд тавих зарчмыг баримтална. Гэвч дээр өгүүлсэнчлэн усжуулалтын үр ашиг багатай гар худгийг ашиглах тохиолдолд худгийн ойр орчимд усалгаа хүлээсэн олон тооны мал багширч, бэлчээрийг нь талхадуулах магадлал бий. Иймд гар худгийн оронд өрөмдмөл худаг гаргах асуудлыг судалж үзэх нь зүйтэй.

iii) Мал усалгааны цагийг зохицуулах, худаг ашиглалтад дарааллын журмыг нэвтрүүлэх

Өвөлжөө, хаваржааны ойролцоох бэлчээрт худаг сэргээн засварлах, шинээр гаргахын хамт одоо ашиглаж байгаа худгийн усалгааны аргыг сайжруулна. Ялангуяа гар худаг нь усалгааны хүчин чадал бага (жилдээ 214 хонин толгой/цаг) тул олон тооны малыг богино хугацаанд услахад бэрхшээл учирдаг байна. Иймд худгийн ойролцоох бэлчээрт усалгаа хүлээсэн мал удаан хугацаагаар багширч, бэлчээрийн ачааллыг нэмэгдүүлэн, хэт ашиглалтыг үүсгэн, бэлчээрийг доройтуулдаг. Ийм байдалд орохоос сэрэмжлэх зорилгоор гар худаг болон түүний ойр орчмын худгуудыг сэлгэн ашиглах ус, бэлчээрийн зүй зохистой ашиглалтын аргыг бий болгоно.

iv) Өвөлжөө, хаваржааны байгууламжийг сайжруулах

Уст цэгийг байгуулах, ашиглалтын арга хэлбэрийг нь сайжруулахын зэрэгцээ, малын хашаа хороо, өвс тэжээлийн агуулах саравч зэрэг мал өвөлжүүлэх байгууламжийг засварлах, сайжруулах ажлыг хийнэ.

2) Бага ашиглалттай болон ашиглалтгүй бэлчээрийг эзэмших төлөвлөгөө.

Энэ төлөвлөгөөг хэрэгжүүлэх хүрээнд малчдын бүлэг, төв болон орон нутгийн засаг захиргааны зүгээс авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг 5.2.11 дүгээр хүснэгтэд тоймлон харуулав.

Хүснэгт 5.2.11 Бага ашиглалттай болон ашиглалтгүй бэлчээрийг эзэмших төлөвлөгөө

	Үйл ажиллагааны чиглэл	Малчдын бүлгийн үйл ажиллагаа	Сум, аймгийн ЗДТГ-ын үйл ажиллагаа	Улс, хандивлагчдын үйл ажиллагаа
1	- Өрөмдмөл худгийг засах шинээр гаргах - Туслах байгууламжийг сайжруулах	- Услах байгууламж барихад шаардлагатай хүн хүч гаргах - Сургалтад хамрагдах	- Худгийн онгоц, усан санг төсөллөх - Сургалт зохион байгуулах	- Уст цэг байгуулах - Худгийн онгоц, усан сан төсөллөх ажлыг зааварчлан чиглүүлэх
2	- Малчдын бүлгийг байгуулах	- Бүлгээрээ худгийнхаа засвар арчлалтыг зохион байгуулалттайгаар хэрэгжүүлэх тогтолцоотой болох	- Малчдын бүлгийн үйл ажиллагааг хянах, зохицуулах	- Малчдын бүлэг байгуулах ажлыг зааварчлан чиглүүлэх

Зуслан, намаржаанд нуур, тогтоол ус зэрэг уст цэгийг бас ашигладаг боловч энэ нь жилийн турш орох хур тунадасны хэлбэлзэлээс ихээхэн хамаардаг, тогтвортой бус эх үүсвэр юм. Бага ашиглалттай ба ашиглалтгүй бэлчээрийг эзэмших асуудлыг голлон авч үзсэн худаг байгуулалтын төлөвлөгөөний талаар 5.2.3-д өгүүлнэ.

Ингээд худаг байгуулалттай холбогдуулан, худгийн ашиглалтыг сайжруулах зорилгоор бэлчээрийн менежментийн төлөвлөгөөнд баримтлах чиглэлийг танилцуулъя.

1) Зуслан, намаржаанд услах байгууламж байгуулах ба улирлын чанартай отор, нүүдлийг дэмжих

Бэлчээрийг 4 улирлаар сэлгэн отор нүүдэл хийж ашиглах нь хамгийн тохиромжтой арга юм. Гэвч зуслан, намаржаанд найдвартай уст цэг байхгүйгээс нүүдэл хийхгүй байх хандлага ажиглагдаж байна. Үүний цаана малчин өрх ба малын тоо ихээхэн нэмэгдэж, улирал бүрт отор хийхэд хэцүү болсон нөхцөл байдал байгаа юм. Төслийн хүрээнд улирлын чанартай нүүдлийг сэргээх, идэвхижүүлэх ажлын эхний алхам болгож, жилд доор хаяж 2 удаа отор хийх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор зуслан (намаржаан)-д өрөмдмөл худаг гаргана. Ингэхдээ отор нүүдлийн бэрхшээл, хүндрэлийг харгалзан үзэж, алслагдсан нутгийн ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээр гэхээсээ илүү өвөлжөө, хаваржаанд ойрхон газраас эхлэн ашиглах боломжтой бэлчээрийн талбайг үе шаттайгаар нэмэгдүүлж явах чиглэлийг баримтлах болно.

ii) Сургалт зохион байгуулах

Малчдын бүлэг худаг, бэлчээрийг зохион байгуулалттай, төлөвлөгөөтэй ашиглаад явах нөхцлийг хангахын тулд энэ талаархи малчдын ойлголт ухамсрыг дээшлүүлэх зайлшгүй шаардлагатай. Үүний тулд аймаг, сумын ЗДТГ, багийн холбогдох хүмүүсийн оролцоотойгоор малчдад зориулсан бэлчээрийн ашиглалт, менежментийн семинар, сургалтыг зохион байгуулж, тухайн орчныг ойлгох чадварыг нь дээшлүүлэх боломжийг олгож явна. Бэлчээрийн даацад тодорхой зөвшөөрөгдөх хүрээ байдаг бөгөөд худгийн ойр орчимд байлгах малын тоонд тодорхой хязгаар байх ёстой гэсэн ойлголтыг олон түмэнд олгохыг зорино.

iii) Өрөмдмөл худгийн ашиглалтын технологийг бий болгох

а. Өрөмдмөл худгийн ашиглалтад хийх мониторингийн тогтолцоо

Өрөмдмөл худгийн усжуулалтын үр ашиг нь өндөр тул богино хугацаанд олон тооны малыг услах боломжтой (жилд дунджаар 900 толгой (хонин толгойд шилжүүлснээр) /цаг). Хэдийгээр усжуулалтын үр ашиг өндөр боловч худгийн ундрагын боломжоос илүү гарсан олон тооны мал нэгэн зэрэг бөөгнөрч ойр хавийн бэлчээрийг талхах сөрөг үр дагавар ч бас бий. Иймд Сумын ЗДТГ-аас худгийн ойр орчмын бэлчээрийн даац болон уст цэг (худаг) ашиглалтаас хамаарах төвшинд байнга мониторинг хийж байна.

б. Услах байгууламжийн хэлбэр, овор хэмжээ, байршлыг боловсронгуй болгох нь

ХХААЯ-наас малын төрөл тус бүрээр тогтоосон 1 өдөрт ноогдох усалгааны нормыг дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5.2.12 Усалгааны норм

Малын төрөл	1 мал 1 өдөрт уух усны хэмжээ (Литр)		
	Хавын сүүл-намрын эхэн	Намрын сүүл-хаврын эхэн	Дундаж
Тэмээ	55	40	48
Адуу	40	30	35
Үхэр	40	30	35
Хонь	5	3	4
Ямаа	5	3	4

Эх сурвалж: ХХААЯ

Дараахь хүснэгтэд худгийн төрөл тус бүрээр ундаргын хэмжээг харуулав.

Хүснэгт 5.2.13 Худгийн төрөл тус бүрийн ундаргын хэмжээ

	Дундаж үзүүлэлт (Литр/секунд)	1 цагт услах малын тоо (хонь)		
		Зун-Намар	Өвөл-Хавар	Дундаж
Өрөмдмөл худаг	3.273	2357	3928	2946
Богино яндант худаг	0.775	558	930	698
Уурхайн худаг	0.455	328	546	410
Гар худаг	0.238	171	286	214

Эх сурвалж: Геоэкологийн хүрээлэнгийн Мэдээллийн сан

Зах зээлд шилжсэнээс хойш малчдын сүргийн бүтэц ихээхэн өөрчлөгдөж бод, бог малыг нэг худгаас услах болсон нь худгийн ашиглалтыг ярвигтай болгосон байна. Иймд нэгдлийн үеийнхтэй адил нэг төрлийн малыг нэг худгаас услах хэлбэрээр нэгдсэн төлөвлөгөө боловсруулах боломжгүй болж байна. Худаг тус бүрийн ашиглалтын байдал хоорондоо харилцан адилгүй байхаас гадна худгийн ашиглалтад тухайн нутаг орны онцлог, малчдын зан харилцааны ялгаа ажиглагддаг байна. Ийм нөхцөлд худаг тус бүрийн онцлог, ашиглалтын нөхцөл байдлыг сайтар судалсны үндсэн дээр зохих арга хэмжээг авч явах шаардлагатай юм.

Бэлчээрийн менежментийн талаас аваад үзэхэд өрөмдмөл худгийн орчимд мал ус хүлээх цагийг багасгах нь ойр хавийн бэлчээрийн ургамлыг хамгаалах эхний алхам юм. Иймд худгийн усжуулах хүчин чадлыг нэмэгдүүлэх үүднээс усан сан, онгоц зэрэг усжуулах байгууламжийг байрлуулах асуудлыг судалж үзэн, мал усалгааны үр ашигтай арга замуудыг эрэлхийлэн, туршин хэрэгжүүлэх шаардлагатай юм. Өрөмдмөл худгийг ашиглахтай холбоотойгоор мал, бэлчээрийн менежментийн арга технологийг бий болгоход ач холбогдолтой 2 зүйлийг өгүүлье.

#1 Худгийн онгоцыг сайжруулах

Олон малтай малчдын бүлэг худаг ашиглах тохиолдолд, усалгаа хүлээх цагийг богино болгохын тулд онгоцыг малын тоонд тааруулан, аль болох олон мал нэгэн зэрэг ус уух боломжтой хэмжээгээр төлөвлөнө. Мөн онгоцыг худгаас тал тал тийш нь цацраг хэлбэрээр байрлуулах зэргээр богино хугацаанд мал усалж дуусах арга замуудыг эрэлхийлнэ.

#2 Усан сан байрлуулах

Бэлчээрийн менежментийн талаас усан сан байрлуулахын давуу талыг дараахь байдлаар тодорхойлж болно.

- Мал худагт ирэх үед усалгааг эхлэх боломжтой болно.
- Ус хуримтлуулснаар худгийн хүчин чадлын хомсдолыг нөхөж, усалгаа хүлээх цагийг богиносгоно.
- Өрөмдмөл худаг ашиглаж сураагүй хүүхэд, эмэгтэйчүүд малаа хялбархан услах боломжтой болно.

5.2.3 Худаг байгуулалтын ажлыг сайжруулах

(1) Худаг байгуулалтын ажлыг сайжруулах төлөвлөгөөний зорилго

Бүс нутагт худаг байгуулалтын ажлыг хэрэгжүүлэн, "одоо ашиглаж буй бэлчээрийн усжуулалтын үзүүлэлтийг дээшлүүлэх", "ашиглалтгүй болон бага ашиглалттай бэлчээрийг эзэмших замаар ашиглах боломжтой бэлчээрийн

талбайг нэмэгдүүлэх” зорилтыг ханган биелүүлснээр бэлчээрийн зүй зохистой ашиглалтыг бодит зүйл болгож чадна.

Ингэснээр 2004-2008 оны Засгийн газрын Үйл ажиллагаагааны хөтөлбөрт тусгагдсан “Засаг захиргааны хүчээр говь, хээрийн бүсэд 1900 инженерийн худгийг засварлаж, 800 худгийг шинээр гаргаж, малчид бие даан гар худаг гаргах ажлыг эрчимжүүлэх” зорилтыг хэрэгжүүлэхэд хувь нэмэр оруулна.

(2) Худаг байгуулалтын ажлын үндсэн чиглэл

Худаг байгуулалтын ажилд баримтлах үндсэн чиглэлийг дараах байдлаар тоймлон харуулав.

1) Худаг байгуулалтын ажлыг малчдын санал, хүсэлтэд үндэслэн хэрэгжүүлэх
Бэлчээр нь ургамлын төрөл болон ойр хавийн орчин нөхцлөөсөө хамааран мал аж ахуйд янз бүрийн зорилгоор ашиглагдах боловч тухайн бэлчээрийг ашиглах хүсэл сонирхол малчдад байх нь худгийн тогтвортой ашиглалт, хамгаалалтын урьдчилсан нөхцөл болно. Иймд худаг байгуулалтын ажлыг ойр хавийн малчдын санал, хүсэлтэд тулгуурлан хэрэгжүүлнэ. Нөгөө талаар сумын ЗДТГ гамшиг, эрсдэлийн нөхцөл байдлыг хянаж байх шаардлагын үүднээс худаг байгуулалтын ажлыг бүс нутгийн хэмжээнд тэнцвэртэйгээр хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулж байх нь чухал.

2) Худаг байгуулалтын ажлыг бэлчээрийн менежменттэй цогц байдлаар уялдуулан авч үзэх нь

Худаг байгуулалтын ажлыг бүс нутгийн хэмжээний бэлчээрийн менежментийн тогтолцоонд малчдыг татан оролцуулах хэрэгсэл болгон идэвхитэй ашиглана. Бэлчээрийн менежментийг хэрэгжүүлэхэд малчдын зүгээс шаардагдах оролцоо, хамтран ажиллах чиглэлүүдийг худаг ашиглалтын гэрээнд үүрэг болгон тусгана.

3) Худгийн ажилтай нэгэн зэрэг худгийн засвар, арчлалтын тогтолцоог бий болгох арга хэмжээг авах.

Худгийг ашиглаж эхэлснээс хойш байнга арчлан хамгаалж явах шаардлагатай тул худаг гаргах ажилтай нэгэн зэрэг худгийн засвар, арчлалтын тогтолцоог бий болгоход чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Малчдыг зохион байгуулалтанд оруулж, худгийн арчилгаа, хамгаалалтын талаар хүлээх хариуцлагыг нь тусгасан гэрээ байгуулна.
- Худгийн ажлын явцад өөрсдийнх нь худаг гэсэн ойлголт, ухамсрыг нь өндөржүүлэх үүднээс малчдын бүлгийн зүгээс худгийн ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх арга хэмжээг зохион байгуулна.

- Худгийн арчилгаа, хамгаалалтанд эзэн хүний ёсоор хандах сэтгэл зүйг төлөвшүүлэх, хариуцлагыг нь өндөржүүлэх зорилгоор үр шимийг хүртэгчдээр тодорхой хэмжээний зардал хариуцуулна.
- Худгийн арчилгаа, хамгаалалтанд шаардлагатай бүлгийн дотоодын хуримтлалыг хийх, бүлгийн гишүүдийн ажил үүргийн хуваарийг тордруулахыг үүрэг болгоно.
- Сумын ЗДТГ-т малчдын бүлгүүдэд дэмжлэг үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалтыг бий болгоно.

4) Хуучин худгийг үр бүтээлтэй ашиглах

Одоогоор ашиглах боломжгүй хуучин худаг олон байдаг. Эдгээр худгуудыг засварлах нь шинээр худаг гаргасанаас хямдхан тусах тул хуучин худгуудыг засварлан ашиглах ажлыг нэн тэргүүнд авч хэрэгжүүлнэ. Тухайн худгийг сэргээн засварлах боломжгүй тохиолдолд ус гарах магадлал өндөр байх үүднээс уг худгийн үзүүлэлтүүдийг ашиглан дэргэд нь шинээр худаг гаргана.

5) Шинэ худаг гаргах

Уст цэггүй бэлчээрийг эзэмших шаардлагын үүднээс усны хайгуулын үр дүнд уст цэг гаргах магадлалтай нь тогтоогдсон газруудыг сонгон шинээр худаг гаргах шаардлагатай ба үүнийг хуучин худгийг засварлах ажилтай зэрэгцүүлэн явуулна.

6) Худгийн байршил(тархалт)-ын үр ашигтай байдлыг хангах.

Шинээр гаргах буюу сэргээн засварлах инженерийн хийцтэй худгийн (өрөмдмөл худаг, богино яндант худаг, уурхайн худаг) байршлыг сонгохдоо уст цэгээс 3 км-ийн радиустай хүрээнд ашиглах боломжтой, тогтвортой усжуулагдсан бэлчээр (3-км-ийн радиустай тойрог) бий болох нөхцлийг судалж үзнэ. Тодруулбал шинээр, гаргах сэргээн засварлах худгийн байршлыг хуучин худгаас 6 км алслагдсан байхаар тогтооно. Гэхдээ энэ хүрээнд орсон гар худаг, булаг шанд зэрэг уст цэг нь усжуулалтын үр ашгийг сайжруулахад хувь нэмэр оруулж, өрөмдмөл худаг эвдрэхэд орлох зэргээр бэлчээр ашиглалтыг тогтворжуулахад үүрэг гүйцтгэдэг тул ус цэгийн давхардал гэж үзэхгүй.

7) Ажил хийгдэх худгийг эдийн засгийн үр ашигтай талыг бодолцон сонгох нь

1) Засварлах худаг

Ундарга багатай худаг дээр хангалтай хэмжээний ус өргөхөд ихээхэн цаг шаардагдана. Иймд ашиглалт ба арчилгаа хамгаалалтын зардлыг нь тооцоод үзэхэд мотор, насосыг хослуулан ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй байх тохиолдол олон байдаг. Энэхүү төслийн хүрээнд 0.6л/с-ийг жишиг болгон авч үүнээс бага ундаргатай худгуудыг сэргээн засварлаагүй. Эдгээр худгуудын хувьд цаашид салхины сэнс, нарны зай зэрэг сэргээгдэх эрчим

хүчний эх үүсвэрийг ашиглан, ус өргөх зардлыг хямдруулах арга замуудыг судалж үзэх шаардлагатай.

ii) Шинээр гаргах худаг


Шинэ худгийг, усны хайгуулын үр дүнг үндэслэн бага гүнтэй нь тогтоогдсон газруудаас эхлэн гаргана. Гэхдээ ойр хавийн хуучин худгуудын усны чанар, ундрага зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үзэж, сонголт хийнэ.

(3) Хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт

Худаг, уст цэгийг байгуулах ажлыг 2005 оны 7 сард батлагдсан “Инженерийн хийцтэй худаг, уст цэгийг сэргээн засварлах, шинээр гаргах, санхүүжүүлэх, эзэмших, ашиглах нийтлэг журам”-ын дагуу явуулна.

Малчдын бүлгийн хүсэлтийг сумын ЗДТГ, аймгийн ХХААГ зэрэг орон нутгийн засаг захиргааны байгууллагууд нэгтгэн авч, улсын төсөв болон бусад хандивлагчдын хөрөнгөөр худаг байгуулалтын ажлыг гүйцэтгэнэ.

5.2.5 дугаар зурагт худаг байгуулалт, худгийн арчилгаа, хамгаалалт, бэлчээрийн ашиглалтын менежментийг хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалт, оролцогч талуудын ажил үүргийн хуваарийг харуулав.



Зураг 5.2.5 Худаг байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх арга хэлбэр ба ажил үүргийн хуваарь.

Ажлын цаг хугацааны нарийвчилсан графикийг 5.2.6 дугаар зурагт харуулав. ХХААЯ-наас гаргасан журмыг мөрдвөл малчдын хүсэлтийн дагуу сэргээн засварлах, шинээр гаргах худгийг сонгож авснаас хойш худгийг ашиглагчдад нь хүлээлгэн өгөх хүртэл 2 жил шаардагдана.

Шинээр худаг байгуулах, сэргээн засварлах ажлын график (Төсөл)		1 дэх жил												2 дахь жил											
Хийгдэх ажил	Оролцогч (хариуцагч)	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Сумын ЭДТГ малчдын бүлэг байгуулна.	Сумын ЭДТГ																								
Малчдын бүлэг зардалын нэг хэсгийг төлнө	Малчдын бүлэг	★ (Бүртгэлийн хэлс)																							
Шинээр байгуулах, засварлах хугдгийн жагсаалтыг гаргана	Малчдын бүлэг, сум, аймгийн ЭДТГ																								
Худаг байгуулалтын төлөвлөгөөний оновчтой байдлыг судална.	Төсөл																								
Сэргээн засварлах боломжийн судалгаа, физикийн судалгаа	Төсөл																								
Шинээр байгуулах, сэргээн засварлах хугдуудийг тогтоох	Төсөл, сум, аймгийн ЭДТГ																								
Материал хэрэгслийн нийлүүлэлт (тендер, гэрээ, нийлүүлэлт)	Төсөл, ХХАА-н Яам																								
Худаг гаргах, засварлах ажлын тендер	Төсөл, аймгийн ЭДТГ																								
Малчдын бүлгүүд хариуцах зардалаа бүрэн төлөх	Малчдын бүлэг																								
Шинээр худаг гаргах, сэргээн засварлах ажил	Төсөл																								
Худаг ашиглалтын гэрээ	Сумын ЭДТГ, малчдын бүлэг, төсөл																								

Зураг 5.2.6 Худаг байгуулалтын ажлыг хэрэгжүүлэх арга хэлбэр

(4) Ирээдүйн төлөвлөгөө

1) Зорилтыг тодорхойлох

Аймгуудын бэлчээрийн өнөөгийн байдлыг үндэслэн нийт бэлчээрийг усжуулах магадлалыг харгалзан үзэж, ирээдүйн худаг байгуулалтын төлөвлөгөөний зорилтот тоо хэмжээг тодорхойлов. Бэлчээрийн байдал харьцангуй сайн хээр, а говь-хээрийн бүсэд нийт талбайн 90% хүртэл, говийн бүсэд 70% хүртэлхийг худаг байгуулалтад хамруулах зорилт тавилаа. Ингэснээр ирээдүйн төлөвлөгөөнд тусгагдах аймгуудын бэлчээрийн талбай ба бэлчээрийн даацын зорилт нь Дорноговь аймгийн хувьд 67,007(km²), 2,629,000 (хонин толгой), Дундговь аймгийн хувьд 90,759 (km²), 2,824,000 (хонин толгой), Өмнөговь аймгийн хувьд 129,185 (km²), 2,724,000 (хонин толгой) болох юм.

Төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээрийн даацын зорилтыг 2004 он болон 1999 оны зуд болохын өмнөх малын тоо толгойн (хонин толгойд шилжүүлснээр) үзүүлэлттэй харьцуулан үзэхэд Дундговьд аймгийн 2004 оны малын тоо толгой нь төлөвлөгөөний зорилтыг 100% хангаж, 1999 оны малын тоо толгой нь төлөвлөгөөний зорилтоос давж гарч байна. Иймд энэхүү төлөвлөгөөг хэрэгжүүлсэн тохиолдолд ч Дундговь аймгийн бэлчээрийн даац нь одоогийн малын тоо толгойг тогтвортой хадгалахад хангалттай хүрэлцэх боловч малыг 1999 оны зудын өмнөх тоо хэмжээнд хүргэж өсгөхөөс илүү малын чанарыг дээшлүүлэхийг зорих гэх мэт худаг байгуулалтаас өөр арга хэмжээнүүдийг ч авч хэрэгжүүлэх шаардлага гарна.

Хүснэгт 5.2.14 Бэлчээрийн төрөл тус бүрээр тавигдах бэлчээр ашиглалтын зорилт

Бэлчээрийн төрөл	Бэлчээрийн даац	Бэлчээр ашиглалтын зорилт
Говь	0-0.156	70%
Говь-хээр, хээр	0.156 -ээс дээш	90%

Хүснэгт 5.2.15 Ирээдүйн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт(1000 толгой : Бэлчээрийн даац)

Төлөвлөгөөний зорилт*	Талбай(км ²) *Бэлчээрийн даац(1000 хонь)	Дундговь	Дорноговь	Өмнөговь
		67 007	90 758	129 185
		2 629	2 824	2 724
2004 он(одоогийн)малын тоо (2004 оны малын тоог төлөвлөгөөний зорилттой харьцуулахаад)		2 642	1 836	1 664
		100%	65%	61%
1999 оны малын тоо (1999 оны малын тоог төлөвлөгөөний зорилттой харьцуулахад)		3 859	2 328	2 706
		147%	82%	99%

2) Төлөвлөгөөнд тусгагдах тоо, хэмжээ

Төлөвлөгөөнд ашиглахаар тусгагдсан бэлчээрийн талбайгаас одоо ашиглагдаж буй тогтвортой усжуулалттай бэлчээрийн талбайг хасаад гарсан талбайг шинээр эзэмших бэлчээр гэж үзсэн болно. Энэхүү бэлчээрийг ашиглахад шаардлагатай худгийн тоо, хэмжээг худаг байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж байна.

и) Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал

Уст цэгийн байршлын (тархалт) өнөөгийн байдлыг үндэслэн тогтвортой усжуулалттай 3 км, 5 км-ийн радиустай тойрогт ноогдох бэлчээрийн талбай, бэлчээрийн даацыг нэгтгэн тооцоолов.

Хүснэгт 5.2.16 Бэлчээр ашиглалтын өнөөгийн байдал

	Бэлчээрийн талбай(км ²)			Бэлчээрийн даац(1000 хонь)		
	Дундговь	Дорноговь	Өмнөговь	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Төлөвлөгөөний зорилт	67,007	90,758	129,185	2,629	2,824	2,724
Тогтвортой усжуулагдсан бэлчээр (3- км-ийн радиустай тойрог)	44,967	47,401	63,980	1,778	1,293	1,286
Тогтвортой усжуулагдсан бэлчээр (3- 5км-ийн радиустай тойрог)	17,891	31,287	36,065	369	517	495
Тогтвортой усжуулагдсан бэлчээр (5км-ийн радиустай тойрог)	62,858	78,688	106,771	2,148	1,810	1,780
Уст цэгийн Тоо	Өрөмдмөл худаг	70	134	85	-	-
	Богино яндант худаг	21	12	109	-	-
	Уурхайн худаг(насосстой)	-	56	-	-	-
	Уурхайн худаг (гар)	1,219	1,102	676	-	-
	Гар худаг	1,497	1,380	2,002	-	-
	Булаг, шанд	143	135	506	-	-
	Нуур, тойром	503	8	530	-	-
Уст цэгийн нийлбэр	3,453	2,827	3,908	-	-	
1 уст цэгт ноогдох эхний үе шатны төлөвлөгөөгөөр усжуулагдах тогтвортой ашиглалттай бэлчээрийн талбай	13	17	16	0.515	0.457	0.329
1 уст цэгт ноогдох тогтвортой ашиглалттай бэлчээрийн талбай	18	28	27	0.622	0.640	0.456

Тэрчлэн, ГМС-ийн үзүүлэлтүүдийг нөхцөл болгон авч, худаг ашиглалтын өнөөгийн байдлыг тодруулав.

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Өрөмдмөл худаг	Ажиллагаатай гэж бүртгэгдсэн	Ажиллагаатай гэж бүртгэгдсэн	Ажиллагаатай гэж бүртгэгдсэн
Богино яндант худаг	Ажиллагаатай гэж бүртгэгдсэн	Ажиллагаатай гэж бүртгэгдсэн	Ажиллагаатай гэж бүртгэгдсэн
Уурхайн худаг	Худгуудын байдал тодорхой бус тул бүх худгийг гар ажиллагаатай гэж авав.	1998 оноос хойш зассан худгийг насостой худаг гэж авав.	Худгуудын байдал тодорхой бус тул бүх худгийг гар ажиллагаатай гэж авав.
Гар худаг		Байгаа мэдээлэл дээр үндэслэн Эрдэнэ, Улаанбадрах, Хөвсгөл сумын ашиглах боломжгүй нь тогтоогдсон 60 худгийг хасав.	

ii) Хамрагдах талбай

Уст цэгийн байршлын (тархалт) өнөөгийн байдлыг үндэслэн тогтвортой усжуулалттай бэлчээрийн (3 км-ийн радиустай тойрог) талбайг тооцоолон гаргаж, үлдсэн талбайг нь уст цэг байгуулах шаардлагатай бэлчээр гэж үзэв. Энэ нь Дундговь аймгийн хувьд 22,040 км², Дорноговь аймгийн хувьд 43,357км², Өмнөговь аймгийн хувьд 65,205км² болох тооцоо гарч байна. Тэрчлэн одоо ашиглагдаж байгаа тогтвортой усжуулалттай талбайн бэлчээрийн (3км-ийн радиустай тойрог) даацыг төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээрийн даацын зорилттой харьцуулан үзвэл Дундговь аймагт 851,000 (хонь), Дорноговь аймагт 1,531,000 (хонь), Өмнөговь аймагт 1,438,000 (хонь) толгойгоор бэлчээрийн даацыг нэмэгдүүлэх шаардлагатай болно.

Хүснэгт 5.2.17 Эзэмших(нэмэгдүүлэх) боломжтой бэлчээрийн талбай ба түүний даац

	Бэлчээрийн талбай (км2)			Бэлчээрийн даац (1000 хонь.)		
	Дундговь	Дорноговь	Өмнөговь	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Тогтвортой усжуулалттай 3 км-ийн радиустай тойргийн бэлчээр	22,040	43,357	65,205	851	1,531	1,438
Тогтвортой усжуулалттай 5 км-ийн радиустай тойргийн бэлчээр	4,149	12,070	22,414	481	1,014	944

iii) Төлөвлөсөн худгийн тоо

Худгийн давхардлыг харгалзан, нэг худаг гаргаснаар ашиглах боломжтой болох бэлчээрийн талбайн хэмжээг өнөөгийн байдлаар нэг уст цэгийн усжуулж буй бэлчээрийн талбайтай адилхан хэмээн үзэж, төлөвлөгөөнд тусгагдах худгийн тоог тооцоолсон болно. 3 аймгийн хэмжээнд тогтвортой усжуулалттай 3 км-ийн радиустай тойргийн бэлчээрээр аваад үзэхэд 8,261, 5 км-ийн радиустай тойргийн бэлчээрээр аваад үзэхэд 1,482 худаг тус тус шинээр гаргах шаардлагатай гэсэн тооцоо гарч байна.

Одоо ашиглаж байгаа уст цэгтэй нийлүүлээд ирээдүйн төлөвлөгөөнд тусгагдах уст цэгийн тоог 3 км-ийн радиустай тойргийн тогтвортой усжуулалттай бэлчээрээр авч үзвэл Дундговь аймагт 3,681, Дорноговь аймагт 3,261, Өмнөговь аймагт 4,728 байх тооцоо гарч байна.

Хүснэгт 5.2.18 Шаардлагатай уст цэгийн тоо

		Дундговь	Дорноговь	Өмнөговь	Нийт
Шинээр гаргах	3км-ийн радиустай тойрог .Тогтвортой усжуулагдсан бэлчээрээс (3км-ийн радиустай тойрог) бусад бэлчээрийг ашиглахад хүрэлцэхүйц байхаар тооцоолсон тохиолдолд	1,692	2,568	3,989	8,261
	5 км-ийн радиустай тойрог. Тогтвортой усжуулагдсан бэлчээрээс (5 км-ийн радиустай тойрог) бусад бэлчээрийг ашиглахад хүрэлцэхүйц байхаар тооцоолсон тохиолдолд	228	434	820	1,482
Нийт уст цэгийн тоо	Тогтвортой усжуулагдсан бэлчээр (5км-ийн радиустай тойрог). Нэмж эзэмших бэлчээрт хүрэлцэхүйц байхаар тооцоолсон тохиолдолд	3,681	3,261	4,728	11,670
	Тогтвортой усжуулагдсан бэлчээр (3 км-ийн радиустай тойрог).Нэмж эзэмших бэлчээрт хүрэлцэхүйц байхаар тооцоолсон тохиолдолд	5,145	5,413	7,891	18,449

(5) Худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөө

Дээр дурьдсан мастер төлөвлөгөөг бүхэлд нь хэрэгжүүлэхэд урт хугацаа шаардагдана. Гэвч хуучин худгийг сэргээн засварлах, орлуулан шинээр гаргах, өмнө хийгдсэн геофизикийн хайгуулын үр дүнг үндэслэн худаг байгуулалтын ажлыг урагшлуулах зэрэг нь эхний ээлжинд бодитойгоор хэрэгжүүлэх боломжтой ажил юм. Иймд хуучин худгийг сэргээн засварлах ажлыг голлон авч үзсэн худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөөг боловсруулав.

1) Төлөвлөгөөнд тусгагдах тоо хэмжээ

1) Төлөвлөгөө боловсруулахад баримтлах үндсэн чиглэл

а. Тооны давхардлыг арилгах

Тухайн худгийн ундрага хангалттай байх тохиолдолд түүний зэргэлдээх худаг нь бэлчээр усжуулалтын төвшин, мал усалгааны үр ашгийг дээшлүүлэхэд нэг их хувь нэмэр оруулахгүй. Иймд ажлын зардал, засварлах боломжтой эсэхийг нь харгалзан ундрага, усны төвшин, хэдийд гаргасан, урьд нь засварлаж байсан эсэх зэрэг мэдээллүүдийг үндэслэн 3 км-ийн радиустай тойргийн дотор зэргэлдээ орших гүний өрөмдмөл худаг, богино яндант худаг, уурхайн худгуудаас төлөвлөгөөнд хамрагдах худгуудыг сонгон авлаа.

б. Инженерийн хийцтэй худгийн ундрагын шаардлагатай хэмжээ

Худгийн ундрага бага бол шаардлагатай хэмжээний ус өргөхийн тулд урт хугацаагаар мотор ажиллуулах бөгөөд тэр хэмжээгээр эдийн засгийн хувьд үр ашиггүй байдаг. Иймд ховоогоор ус татахтай адил хэмжээ болох 0.6л/с-ээс дээш ундрагыг худагт насос тавих жишиг болгон тогтоов.

Зөвхөн 0.6л/с –ээс дээш ундрагатай уурхайн худгийг л сэргээн засварлаж, насос тавих бөгөөд түүнээс бага ундрагатай уурхайн худгуудыг гар аргаар ашиглах юм. Тэрчлэн 0.6л/с-ээс бага ундрагатай богино яндант худгийг төлөвлөгөөнөөс хассан болно.

в. Цаашид худгийн тоо цөөрөхийг харгалзан үзэх нь

Төлөвлөгөө боловсруулахдаа уурхайн худаг, гар худаг зэрэг ашиглалтын хугацаа нь богино худгийн тоо цаашид цөөрөхийг харгалзан үзэж байгаа болно.

ii) Худгийг төрөл тус бүрээр шинээр гаргах, сэргээн засварлах боломж

Шинээр худаг гаргах, сэргэн засварлахад мөрдөх үндсэн чиг баримтлалыг дараахь байдлаар тоймлож болно.

Худгийн төрөл	Үндсэн чиг баримтлал
Гүний өрөмдмөл худаг	Шинээр худаг гаргах гэхээс илүү сэргээн засварлах ажлыг нэн тэргүүнд авч үзнэ. Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг эзэмших шаардлагаар шинэ худаг гаргана. Мөн сэргээн засварлах боломжгүй худгийн дэргэд орлуулан гаргана.
Богино яндант худаг	Зөвхөн эргээн засварлах боломжтой нь тогтоогдсон худгийг засварлана. Ашиглалтгүй ба бага ашиглалттай бэлчээрийг эзэмших шаардлагаар шинэ худаг гаргана. Мөн сэргээн засварлах боломжгүй худгийн дэргэд орлуулан гаргана. Уурхайн худгийг ашиглах боломжгүй болсон тохиолдолд дэргэд нь орлуулан гаргана.
Уурхайн худаг	Бэлчээрийн усжуулалтын үр ашгийг дээшлүүлэх, худгийн ашиглалтыг сайжруулах зорилгод нийцэх худгийг л сэргээн засварлаж, зөөврийн насос суурьлуулна, Шинээр байгуулах боломжгүй тул хуучин худгийн үзүүлэлтийг үндэслэн усны төвшин бага худгийг гар худгийн хэлбэрээр ашиглана. Усны төвшин гүн, ундрага нь арвин худгийн дэргэд орлуулах байдлаар богино яндант худаг гаргана.
Гар худаг	Хуучин худгуудын байршил, тархалтыг эвдэх байдлаар малчдын хүчээр гар худаг гаргах, засварлах ажлыг хийнэ, Засаг захиргааны зүгээс дэмжлэг үзүүлнэ.

а. Гүний өрөмдмөл худаг

Туршилтын судалгаанд хамрагдсан 3 сумын сэргээн засварлах боломжтой худгийн эзлэх хувь 53% болж байна. Төслийн хүрээнд сэргээн засварлах ажлын үр дүн 90% -тай байснаас хуучин худгуудын хагасыг нь сэргээн засварлах боломжтой гэж үзэж байна.

Хүснэгт 5.2.19 Судалгаанд хамрагдсан 3 сумын гүний өрөмдмөл худгийн ашиглалтын төвшин

Сум	Худгийн тоо	Ашиглаж буй худаг	Ашиглах боломжгүй худаг	Засварлах бололцоотой худаг	
				Худгийн тоо	Эзлэх хувь
Эрдэнэ	21	5	16	5	0.31
Улаанбадрах	21	4	17	10	0.59
Хөвсгөл	23	1	22	14	0.64
Нийт	65	10	55	29	0.53

(Эх сурвалж: 2003 он. ЖАЙКА, Судалгааны баг)

Аймгуудын гүний өрөмдмөл худгийн мэдээллийн сангаас үзэхэд сэргээн засварлах боломжтой боловч одоогоор ашиглагдахгүй байгаа худгийн эзлэх хувь Дундговь аймагт 56%, Өмнөговь аймагт 59% байна. Эдгээр худгийг сэргээн засварлахаар төлөвлөгөөнд хамруулж байна. Мөн орлуулан гаргах худгуудийг хамруулсан болно.

сэргээн засварлахаар төлөвлөгөөнд хамруулж байна. Мөн орлуулан гаргах худгуудийг хамруулсан болно.

Дорноговь аймгийн ХХААГ-ын худгийн бүртгэлийн мэдээллийг шинэчилсний үр дүнд байдал нь тодорхой бус худгийн эзлэх хувь 70%-д хүрсэн. Эдгээр худгуудын дотроос 1984 оноос хойш гаргасан худгуудыг сэргээн засварлах боломжтой гэж үзэн, засварлах боломжтой нь нэгэнт тогтоогдсон худгууд дээр нэмж, нийт сэргээн засварлах боломжтой худгуудын тооцоог гаргасан болно.

Хүснэгт 5.2.20 Өрөмдмөл худгийн бүртгэл, мэдээллийг үндэслэн төлөвлөгөөнд тусгасан худгийн тоо

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Сэргээн засварлах	117	74	117
Шинээр гаргах	93	66	114

б. Богино яндант худаг

Богино яндант худгийн сэргээн засварлах ажил амжилтад хүрэх магадлал багатай байдаг тул үнэхээр сэргээн засварлах боломжтой гэж үзсэн худгуудаар хязгаарлан засварын ажлыг хийнэ.

Дорноговь аймгийн худгийн тооллого судалгааны үр дүнд ашиглах боломжгүй богино яндант худгийн 35%-ийг сэргээн засварлах боломжтой гэсэн дүгнэлт гарсан байна. Үүн дээр гүний өрөмдмөл худгийн засварын ажлын үр дүнг харгалзан богино яндант худгийн 30%-ийг сэргээн засварлах боломжтой гэж таамаглаж байна.

Хүснэгт 5.2.21 Ашиглагдахгүй байгаа богино яндант худгийн цооногийг ашиглах боломж

Цооногийн байдал	Эрдэнэ сум	Хөвсгөл сум	Улаанбадрах сум	Нийт
Ашиглах боломжгүй	1	8	0	9
Ашиглах боломжтой	1	4	0	5
	2	12	0	14

(Эх сурвалж: 2003. ЖАЙКА. Судалгааны баг)

Аймгуудын богино яндант худгийн бүртгэл мэдээллээс үзэхэд сэргээн засварлах боломжтой гэсэн дүгнэлт гарсан ашиглагдахгүй байгаа богино яндант худгийн эзлэх хувь Дундговь аймагт 72%, Өмнөговь аймагт 44% буюу өндөр байгаа юм. Эдгээрийн дотроос худгийн ашиглалтын хугацааг нь үндэслэн харьцангуй сүүлд гаргасан худгуудыг засварлахаар тооцон, нийт худгийн 30% байхаар тогтоож, бусдыг нь шинээр гаргах худагт хамруулахаар байна.

Дорноговь аймагт байдал нь тодорхой бус худгийг шинээр гаргах худагт хамруулахаар болсон тул сэргээн засварлах боломжтой худгийн эзлэх хувь бага буюу 15%-тай гарсан болно. Эдгээрээс харьцангуй сүүлд гаргасан худгуудыг сэргээн засварлах худагт хамруулахаар болов.

Хүснэг 5.2.22 Богино яндант худгийн бүртгэл, мэдээллийг үндэслэн төлөвлөгөөнд тусгасан худгийн тоо

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Ашиглагдаж буй	21	2	109
Сэргээн засварлах	52	27	84
Шинээр гаргах	121	58	195

в. Уурхайн худаг

#1 Сэргээн засварлах худгийг сонгох

Уурхайн худгийн хувьд насос суурилуулан худгийн ашиглалтыг механикжуулахыг сэргээн засварлах гэж томъёолсон болно.

Ийм худгийг сэргээн засварлах ажлын зорилго нь усны төвшин гүехэн уурхайн худагт насос тавьж хөдөлмөр, услах цагийг хэмнэхээс гадна ундрарга ихтэй худгийн усалгааны үр ашгийг дээшлүүлэхэд оршино. Иймд насос суурилуулахад худгийн усны төвшин нь 6 м-ээс гүн байх, эсвэл ундарга нь 0.6л/с-ээс дээш байх нөхцлийг тавина.

Хүснэг 5.2.23 Уурхайн худгийн зэрэглэл тус бүрээр засварлах ажлын зорилго

Зэрэглэл	Ундарга, Q = 0.6л/с	Усны түвшин = 6m	Сэргээн засварлах ажлын зорилго
o	o	o	Ус татах гар ажиллагааг хөнгөвчлөх
o	x	o	Ус татах гар ажиллагааг хөнгөвчлөх
o	o	x	Усалгааны бүтээмжийг дээшлүүлэх
x	x	x	Гар худгийн хэлбэрээр ашиглах

#2 Уурхайн худгийн тоо цөөрөх хандлага ба орлуулах худаг гаргах

Дорноговь аймгийн худгийн тооллогын материалаас үзэхэд аймгийн хэмжээнд нийт 1210 уурхайн худаг байдгаас 428 нь ашиглагдахгүй байдалтай байна. Ашиглалтгүй худгийн хагас орчим буюу 234 худгийн цооногийг сэргээн засварлах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Иймд 1960-аад онд гаргасан уурхайн худгууд ойрын 10 жилийн хугацаанд ашиглах боломжгүй болно гэж үзээд цаашид хорогдох худгийн тоог тооцоолон гаргаж, эдгээр худгуудын үзүүлэлт дээр тулгуурлан усны динамик төвшин нь 6 метрээс гүехэн худгийг гар аргаар ашиглах, ундрага нь 0.6л/с –ээс дээш худгийн дэргэд орлуулах байдлаар богино яндант худгийг гаргахаар төлөвлөв. Ялангуяа эдгээр гар худгуудын усны төвшин улам доошлох тул засаг захиргааны зүгээс оролцон худаг гаргах ажлыг өрнүүлэх шаардлагатай.

#3 Төлөвлөгөөнд тусгах тоо хэмжээ

Дээр дурьдсан 2 чиглэлийг баримтлан насос суурилуулах, шинээр гаргах худгийн төлөвлөгөөг гаргав. Насос суурьлуулах худгийн байршлыг гүний өрмийн худаг, богино яндант худгийн тархалтыг үндэслэн 3 км-ийн

радиустай тойрогт өөр инженерийн худагтай давхцахгүй байдлаар сонгохоор тогтлоо.

Хүснэгт 5.2.24 Төлөвлөгөөнд тусгагдсан уурхайн худгийн тоо, хэмжээ

		Дундговь	Дорноговь	Өмнөговь
Нийт тоо	Ашиглагдаж байгаа	1219	393	158
	Засварлах боломжтой	51	679	518
	Ашиглах боломжгүй	227	77	217
	Засварласан	-	56	-
Ашиглах боломжгүй болох худаг(60-аад оны худаг)		237	231	217
Төлөв лөж буй худгийн тоо	Насос тавих	201	227	111
	Гараар ашиглах	889	652	408
	Шинээр гаргах богино яндант худаг	64	45	24
	Шинэ гар худаг	140	17	97

г. Гар худаг

Энэ төлөвлөгөөний хүрээнд худгийн ёроолд дэвссэн чулуу, хайргыг авч, гүнзгийрүүлэн ухах зэрэг шинээр худаг гаргахаас бараг ялгагдахгүй хэмжээний засвар хийхийг гар худгийг сэргээн засварлах гэсэн ойлголтонд хамруулж байгаа болно.

Гар худгийн ашиглалтын хугацааг 20-30 жил гэж үздэг. Мөн үерт автагдан сэргээн засварлах шаардлагатай болох тохиолдол их байдаг. Иймд тодорхой хугацаанд сумуудад 5 худгийг сэргээн засварлах шаардлагатай болно гэж тооцоолоод түүний хагас нь шинээр гаргах худаг, хагас нь засварлах худаг байхаар төлөвлөгөөнд тусгах тоог нь тогтоолоо.

Хүснэгт 5.2.25 Төлөвлөгөөнд тусгагдсан гар худгийн тоо

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Засварлах	375	300	350
Шинээр гаргах	375	300	350

д. Шинээр гаргах худаг

Энэхүү судалгааны төслийн хүрээнд хийсэн геофизикийн хайгуул болон ХХААЯ-ны хийсэн геофизикийн хайгуулын үр дүнг үндэслэн ус гарах боломжтой газарт шинээр худаг гаргахаар төлөвлөв. Гэхдээ усны төвшин 6 метрээс гүехэн газарт гар худаг, 40 метрээс гүехэн газарт богино яндант худаг, түүнээс гүн газарт гүний өрөмдмөл худаг гаргахаар төлөвлөж байгаа болно.

Шинээр худаг гаргах ажил нь i)-iv)-дурьдсан сэргээн засварлах болон орлуулан гаргах ажил дууссаны дараа явагдана гэж тооцоолоод худгийн байршлыг судлаж үзэв.

Хүснэгт 5.2.26 Төлөвлөгөөнд тусгагдсан шинээр гаргах худгийн тоо

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Өрөмдмөл худаг	0	72	16
Богино яндант худаг	78	32	72
Гар худаг	30	7	1

е. Төлөвлөгөөнд тусгагдсан нийт тоо

Дараахь хүснэгтэд худаг байгуулалтын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан худгийн тоо, хэмжээг худгийн төрөл тус бүрээр нэгтгэн харуулав.

Хүснэгт 5.2.27 Төлөвлөгөөнд тусгагдсан худгийн тоо, хэмжээ

Аймаг	Худгийн төрөл	Нийт	Ангилал				Шинээр гаргах
			Өрөмдмөл худаг	Богино яндант худаг	Уурхайн худаг	Гар худаг	
Дундговь	Шинээр гаргах						71
	Өрөмдмөл худаг	144	73				31
	Богино яндант худаг	132		58	43		7
	Гар худаг	323			16	300	
	Сэргээн засварлах						
	Өрөмдмөл худаг	66	66				
	Богино яндант	26		26			
	Уурхайн худаг(насос)	219			219		
Гар худаг	300				300		
Дорноговь	Шинээр гаргах						0
	Өрөмдмөл худаг	93	93				78
	Богино яндант худаг	263		121	64		30
	Гар худаг	543			138	375	
	Сэргээн засварлах						
	Өрөмдмөл худаг	117	117				
	Богино яндант	52		52			
	Уурхайн худаг(насос)	201			201		
Гар худаг	375				375		
Өмнөговь	Шинээр гаргах						10
	Өрөмдмөл худаг	114	104				66
	Богино яндант худаг	260		171	23		1
	Гар худаг	435			84	350	
	Сэргээн засварлах						
	Өрөмдмөл худаг	103	103				
	Богино яндант	71		71			
	Уурхайн худаг(насос)	93			93		
Гар худаг	350				350		

2) Усжуулагдах бэлчээрийн талбай, малын тоо толгойг тооцоолон гаргах нь

5.2.1-д харуулсан тооцооны аргад үндэслэн худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлснээр ашиглах боломжтой болох бэлчээрийн талбай, бэлчээрийн даацыг тооцоолон гаргав.

Худаг байгуулалтын эхний үе шатны төлөвлөгөө хэрэгжсэний дараа төлөвлөгөөний зорилттой харьцуулсан үр дүн нь ямар байхыг авч үзье. Тогтвортой усжуулалттай 3 км-ийн радиустай тойргийн бэлчээрээр аваад үзэхэд бэлчээрийн талбай Дундговь аймагт 75%, Дорноговь аймагт 57%, Өмнөговь аймагт 55% болж, 5 км-ийн радиустай тойргоор авч үзэхэд Дундговь аймагт 100%, Дорноговь аймагт 94 %, Өмнөговь аймагт 90% -д хүрч төлөвлөгөөний зорилт биелэхээр байна.

Бэлчээрийн даацын хувьд тогтвортой усжуулалттай 5 км-ийн радиустай тойргоор авч үзэхэд Дундговь аймагт 87%, Дорноговь аймагт 72%, Өмнөговь аймагт 74%-д хүрэх бөгөөд усжуулалтын төвшинг дээшлүүлэхэд худаг байгуулалтын ажил тодорхой хувь нэмэртэй болох нь харагдаж байна.

Хүснэгт 5.2.28 Тооцооны үр дүнгийн тойм

		Бэлчээрийн талбай (км ²)			Бэлчээрийн даац (1000 хонь)		
		Дундговь	Дорноговь	Өмнөговь	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Төлөвлөгөөний зорилт		67,007	90,758	129,185	2,629	2,824	2,724
Одоо байгаа уст цэг	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (3 км-ийн радиустай тойрог)	44,967	47,401	63,980	1,778	1,293	1,286
	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (3-5 км-ийн радиустай тойрог)	17,891	31,287	36,065	369	517	495
	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (5 км-ийн радиустай тойрог)	62,858	78,688	106,771	2,148	1,810	1,780
Эхний үе шатны төлөвлөгөөг хэрэгжүүлсний дараа	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (3 км-ийн радиустай тойрог)	50,080	51,492	71,660	1,946	1,459	1,489
	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (3-5 км-ийн радиустай тойрог)	16,726	33,818	44,424	353	586	535
	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (5 км-ийн радиустай тойрог)	66,805	85,310	116,084	2,299	2,045	2,024
Эхний шатны төлөвлөгөөг хэрэгжүүлсний дараахи зорилтын биелэлтийн төвшин	Тогтвортой усжуулалттай бэлчээр: (3 км-ийн радиустай тойрог)	0.75	0.57	0.55	0.74	0.52	0.55
	Тогтвортой усжуулалттай бэлчээр: (5 км-ийн радиустай тойрог)	1.00	0.94	0.90	0.87	0.72	0.74
Уст цэгийн тоо	Гүний ерөмдмөл худаг	280	344	302			
	Богино яндант худаг	336	170	440			
	Уурхайн худаг (насостой)	201	275	93			
	Уурхайн худаг (гар)	889	642	349			
	Гар худаг	1,665	1,398	2,087			
	Булаг, шанд	143	135	506			
	Нуур, тойром	503	8	530			
	Уст цэгийн нийлбэр дүн	4,017	2,972	4,307			
1 уст цэгт ноогдох тогтвортой усжуулагдсан бэлчээр (3 км-ийн радиустай тойрог)-ийн талбай ба бэлчээрийн даац		12	17	17	0.484	0.491	0.346
1 уст цэгт ноогдох тогтвортой усжуулагдсан бэлчээр (5 км-ийн радиустай тойрог)-ийн талбай ба бэлчээрийн даац		17	29	27	0.572	0.688	0.470
Эхний шатны төлөвлөгөөг биелүүлснээр нэмэгдэх хэмжээ	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (3 км-ийн радиустай тойрог)	5,113	4,091	7,680	168	167	203
	Тогтвортой усжуулагдсан бэлчээр: (5 км-ийн радиустай тойрог)	3,947	6,622	9,313	151	236	244
Эзэмших бэлчээр(тогтвортой усжуулагдсан 3 км-ийн радиустай тойрогос бусад талбай)		16,927	39,266	57,525	683	1,365	1,235
Эзэмших бэлчээр(тогтвортой усжуулагдсан 5 км-ийн радиустай тойрогос бусад талбай)		202	5,448	13,101	330	779	700
Тогтвортой усжуулагдсан 3 км-ийн радиустай бэлчээрээс бусад эзэмших талбайд хүрэлцэхүйц байхаар тооцвол худгийн тоо хэд байх		1,358	2,266	3,457			
Тогтвортой усжуулагдсан 5 км-ийн радиустай бэлчээрээс бусад эзэмших талбайд хүрэлцэхүйц байхаар тооцвол худгийн тоо хэд байх		12	190	486			

Тэрчлэн тогтвортой ашиглалттай бэлчээр (5 км-ийн радиустай тойрог)-ээр авч үзсэн тохиолдолд Дорноговь, Өмнөговь аймгийн одоо байгаа малын тоо толгойд хүрэлцэх боловч, Дундговь аймгийн хувьд 2004 оны малын тоо толгой нь бэлчээрийн даацаас нь хэтэрсэн байсан үр дүн гарч байна.

Хүснэгт 5.2.29 Одоо байгаа малын тоотой харьцуулахад

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Одоо байгаа (2004 он) малын тоо (1000 хонь)	2,642	1,836	1,664
Одоогийн малын тоог (бэлчээрийн даацад шилжүүлснээр) эхний үе шатны худаг байгуулалтын ажлын үр дүнтэй харьцуулахад	115%	90%	82%



3) Ирээдүйн төлөвлөгөөнд эзлэх байр суурь (Бэлчээрийн талбай, бэлчээрийн даац нэмэгдэх)

Худаг байгуулалтын эхний шатны төлөвлөгөө болон ирээдүйн төлөвлөгөөнд тусгагдсан усжуулагдсан бэлчээрийн талбай, бэлчээрийн даацыг харьцуулан авч үзэв. 3 аймгийн усжуулагдсан бэлчээрийн талбай ба бэлчээрийн даац нь худаг байгуулалтын эхний шатны төлөвлөгөө, ирээдүйн төлөвлөгөөг биелүүлэх явцад одоогийн хэмжээнээсээ нэмэгдэх тооцоо гарч байна.

Аймгуудын нийт бэлчээрийн талбай, бэлчээрийн даацад одоогийн үзүүлэлт болон эхний шатны төлөвлөгөө, ирээдүйн төлөвлөгөөний зорилтын эзлэх хувиар нь аваад үзэхэд ирээдүйн төлөвлөгөөг биелүүлснээр Дундговь аймгийн нийт бэлчээрийн 90%, Дорноговь аймгийн нийт бэлчээрийн 83%, Өмнөговь аймгийн нийт бэлчээрийн 78% нь усжуулагдах боломжтой болох юм.

Хүснэгт 5.2.30 Одоогийн малын тоо толгойтой харьцуулахад

		Бэлчээрийн талбай (км ²)			Бэлчээрийн даац (1000 хонь)		
		Дундговь	Дорноговь	Өмнөговь	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Усжуулагдсан талбай ба бэлчээрийн даац	Одоо байгаа уст цэг	62,858	78,688	106,771	2,148	1,810	1,780
	Эхний шатны төлөвлөгөөний хэрэгжилтийн дараа	66,805	85,310	116,084	2,299	2,061	2,074
	Төлөвлөгөөний зорилт	67,007	90,758	129,185	2,629	2,824	2,724
Аймгийн хэмжээнд эзлэх хувь	Одоо байгаа уст цэг ба бэлчээрийн даац	84%	72%	65%	66%	42%	46%
	Эхний шатны төлөвлөгөөг биелүүлсний дараахь бэлчээрийн даац	89%	78%	70%	71%	48%	54%
	Төлөвлөгөөний зорилт	90%	83%	78%	81%	65%	71%



Зураг 5.2.7 Худаг байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан бэлчээрийн талбай ба уст цэгийн тооны өөрчлөлт

(6) Ажлын зардлыг баримжаалан тооцоолох

1) Стандартын үзүүлэлтүүд

Өрөмдмөл худгийн стандартын үзүүлэлтүүдийг дараахи тооцоог үндэслэн судалж үзэв. 500 орчим толгой малыг услахад 2.5 тонн ус шаардагдах бөгөөд худгийн ундрага 1.0л/с байх тохиолдолд 40 минутанд усалж дуусах тул үүнийг жишиг болгон авлаа. Тэрчлэн усан санг дээрхи тооны малыг 1 удаа услахад хүрэлцэхүйц хэмжээгээр буюу 2.5 тонны багтаамжтай байхаар тооцов.

Гэхдээ олон тооны бод малтай, мал усалгаанд нэг доор их хэмжээний ус шаардагдах малчдын бүлгийн хувьд онгоцоо томсгох, их багтаамжтай усан сан байрлуулах зэрэг мал усалгааны цагийг богиносгоход чиглэсэн арга замуудыг эрэлхийлэх шаардлагатай юм.

Худгийг ашиглагч малчдын бүлгүүдээр зардал хариуцуулж байгаа тул тэдний санал, хүсэлтийг байгууламжийн төлөвлөлтөнд тусгах шаардлагатай бөгөөд засварын ажлын зардал нэмэгдэх тохиолдолд холбогдох зардлаа гаргах эсэхийг нь лавласны дараа худгийн төлөвлөлтийг хийж байх шаардлагатай.

1) Гүний өрөмдмөл ба богино яндант худаг

Гүний өрөмдмөл худаг болон богино яндант худаг нь гүн, ундрагын хэмжээгээрээ ялгагдах боловч, зарчмын хувьд цооногт худгийн төрөлд хамаарна. Социализмын үед ус өргөх насосны төрлөөс хамааран гүний өрөмдмөл худаг туслах байгууламжтай байх зэрэг ялгаа байсан боловч энэхүү төлөвлөгөөний хүрээнд хооронд нь ялгаагүй авч үзэх болно.

Хүснэгт 5.2.31 Гүний өрөмдмөл ба богино яндант худгийн стандартын үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	Тусгайлан тэмдэглэх зүйл
Насос	Ундрагын хэмжээ 1.0 л/с-ийг жишиг болгон авав.	Эвдэрсэн үед засвар хийхэд хүндрэлтэйг харгалзан үзэж аль болох чанарын баталгаатай төхөөрөмжийг сонгох.
Цахилгаан үүсгүүр	Насос ажилуулахад шаардагдах хүчин чадлаас 2-2.5 дахин илүү хүчин чадалтай	Дизель түлшийг сум орон нутагт худалдан авах боломжтой эсэхийг магадлан, түлшний олдоцоос хамааран моторын төрлийг сонгоно. Моторын төрөл сумын хэмжээнд ижил байх нь засвар үйлчилгээний талаасаа хялбар байх болно.
Онгоц	9 м орчим урттай, бетон юмуу төмөр хийцтэй	Малын тоо олон байх тохиолдолд насосны ундрага, усан сантай уялдуулан ашиглаж, онгоцоо уртасгах юмуу 2 онгоц ашиглах асуудлыг судалж үзэх.
Усан сан	2.5м ³ багтаамжтай	{Усны ундрага нь арвин, зуны улиралд олон бод мал цугладаг худаг} -т 3-4м ³ -ын багтаамжтай том оворын усан сан байрлуулах асуудлыг судалж үзэх.
Насосны байр	Тоног төхөөрөмж, худгийг хамгаалах зорилгоор барих	Хамгаалалтын хайрцагар орлуулах тохиолдолд моторыг гаргаж оруулахад хялбар байх боловч моторын утаа дотроо бөөгнөрч моторыг эвдрэлд хүргэхгүй байхаар хийцийг сонгох.

ii) Уурхайн худаг

Хүснэгт 5.2.32 Уурхайн худгийн стандартын үзүүлэлтүүд

	Үзүүлэлт	Тусгайлан тэмдэглэх зүйл
Насос	Шавхах насос	Өвөлд хөлдөөд ашиглах боломжгүй болохоос сэргийлэн насосыг онгоцтой шлангаар холбож, аль болох ус өргөхөд хялбар байхуйц хийцийг сонгох
Цахилгаан үүсгүүр	Насос ажилуулахад шаардагдах хүчин чадлаас 2-2.5 дахин илүү хүчин чадалтай	Дизель түлшийг сум орон нутагт худалдан авах боломжтой эсэхийг магадлан, түлшний олдцоос хамааран моторын төрлийг сонгоно. Моторын төрөл сумын хэмжээнд ижил байх нь засвар үйлчилгээний талаасаа хялбар байх болно.
Онгоц	7м орчим урт, бетон юмуу төмөр хийцтэй.	
Усан сан	Ундрага бага тул усан сан байрлуулахгүй	
Насоны байр	Худгийг хамгаалах байдлаар блок, тоосго зэрэг материалаар барина.	Хамгаалалтын хайрцгаар орлуулах тохиолдолд моторыг гаргаж оруулахад хялбар байх боловч моторын утаа дотроо бөөгнөрч моторыг эвдрэлд хүргэхгүй байхаар хийцийг сонгох. Худагт таг хийх тул бүлгийн гишүүн бус ашиглагчидтай сайтар зохицож ашиглах

iii) Гар худаг

Одоогийн байдлаар ихэвчлэн 3 метр орчим гүнтэй худгийг гаргаж байгаа боловч худгийн гүн нь 6 метр орчим байх нь их тохиромжтой. Худгийн ханыг чулуугаар доторлож, модон материалаар таг хийнэ.

Онгоцны уртыг гар усалгааны үр ашгийг харгалзан 4 метр орчим байхаар тооцно.

Гар худаг гаргах, засварлах ажлыг малчид голлон гүйцэтгэнэ. Гэхдээ сумын ЗДТГ, багийн дарга нар идэвхитэй дэмжлэг үзүүлж, бүс нутгийн хэмжээний асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хамтын ажиллагааны бүтэц, зохион байгуулалтыг бий болгох нь чухал юм.

2) Ажлын зардлын тооцоо

i) Худаг барих зардал

Туршилтын судалгааны явцад сэргээн засварласан / шинээр гаргасан худагт гаргасан зардалд үндэслэн зардлыг тооцоолж гаргасан. Энэ зардалд насос байрлуулах жижиг хамгаалалтын байгууламж барих, мал услах онгоц, ус нөөцлөх сан хийж байрлуулах зардал орсон болно.

Анх 1) Өрөмдмөл худаг, богино яндант худгийн хувьд гүйцэтгэлийн зардлын 10% дээр насос байрлуулах хамгаалалтын байгууламж барих зардал 2000\$, онгоц, ус нөөцлөх сан барих 500\$ - г нэмж тооцсон.

Анх 2) Гар худгийн хувьд малчид өөрсдөө гаргана гэж тооцсон.

ii) Тоног төхөөрөмжийн зардал

Туршилтын судалгааны явцад сэргээн засварласан /шинээр гаргасан худгийн зардлыг үндэслэл болгон усны гүний хэмжээнээс хамааруулан тоног төхөөрөмжийн зардлыг тооцоолж гаргасан.

iii) Байгуулалтын өртөг

Ажлын зардал болон тоног төхөөрөмжийн зардлын нийлбэрийг нийт зардал болгон , шинээр барих болон сэргээн засварлах ажлын өртгийг тооцоолж гаргасан.

Хүснэгт 5.2.33 Нийт зардал өртөг (ам.доллар)

Шинээр гаргах	Байгуулалтын өртөг	Барилгын ажлын зардал	Тооцоот гүн	Тоног төх.зардал	Тооцоот гүн
Өрөмдмөл худаг	12,720	11,160	H=100м	1,560	Х.Г.=40м
Богино яндант	9,130	7,900	H=20м	1,230	Х.Г.=20м
Гар худаг	200	200			

Сэргээн засварлах	Байгуулалтын өртөг	Барилгын ажлын зардал	Тооцоот гүн	Тоног төх.зардал	Тооцоот гүн
Өрөмдмөл худаг	7,280	5,720	H=100м	1,560	Х.Г.=40м
Богино яндант	5,840	4,610	H=20м	1,230	Х.Г.=20м
Уурхайн худаг Насостой	3,580	2,500	-	1,080	-
Гар худаг	200	200			

Анх)Өрөмдмөл худагт худгийн гүнийг 100м, насос байрлуулах гүнийг 40 м , Богино яндант худагт худгийн гүнийг 40 м, насос байруулах гүнийг 20 м гэж урьдчилан тооцсон болно.

iv) Барилгын ажлын зардал

Өртөгт үндэслэн аймаг тус бүрээр нийт зардлыг тооцоолж гаргасан. Үүний үр дүнд худгийг сэргээн засварлах / шинээр барих 1-р шатны төлөвлөгөөнд тусгагдсан барилгын ажлын зардал нь Дундговь аймагт 5,569,000 ам.доллар, Дорноговь аймагт 4,518,000 ам. доллар, Өмнөговь аймагт 5,409,000 ам.доллар болж байна.

Хүснэгт 5.2.34 Нийт зардал өртөг (Ам.доллар)

Аймгийн нэр	Ажлын төрөл	Тоо хэмжээ	Өртөг	Зардал	Дүн	Бүгд
Дунговь	Шинээр гаргах					
	Өрөмдмөл худаг	93	12,720	1,183,000	3,693,000	5,569,000
	Богино яндант	263	9,130	2,401,000		
	Гар худаг	543	200	109,000		
	Сэргээн засварлах					
	Өрөмдмөл худаг	117	7,280	852,000	1,876,000	
	Богино яндант	52	5,840	304,000		
	Уурхайн худаг (насостой)	201	3,580	720,000		
Гар худаг	375	200	75,000			
Дорноговь	Шинээр гаргах					
	Өрөмдмөл худаг	144	12,720	1,832,000	3,102,000	4,518,000
	Богино яндант	132	9,130	1,205,000		
	Гар худаг	323	200	65,000		
	Сэргээн засварлах					
	Өрөмдмөл худаг	66	7,280	480,000	1,416,000	
	Богино яндант	26	5,840	152,000		
	Уурхайн худаг (насостой)	219	3,580	784,000		
Гар худаг	300	200	60,000			
Өмнөговь	Шинээр гаргах					
	Өрөмдмөл худаг	114	12,720	1,450,000	3,911,000	5,409,000
	Богино яндант	260	9,130	2,374,000		
	Гар худаг	435	200	87,000		
	Сэргээн засварлах					
	Өрөмдмөл худаг	103	7,280	750,000	1,498,000	
	Богино яндант	71	5,840	415,000		
	Уурхайн худаг (насостой)	93	3,580	333,000		
Гар худаг	350	200	70,000			

v) Гар худгийн тоног төхөөрөмжийн зардал

Гар худгийн хувьд малчид өөрсдөө хийх зүйл юм. Гэвч бодит байдал дээр малчид өөрсдийн идэвх санаачлагаар биш, сумын захиргаа нь багийн даргаар дамжуулан малчдын оролцоотойгоор худгийн тоог нэмж байна. Худаг дутагдалтай байгааг орон нутгийн бэрхшээлтэй асуудал болгон авч үзэн, малчдад энэ асуудлыг шийдэх арга замыг эрэлхийлэхэд нь сумын захиргаа тасралтгүй дэмжлэг үзүүлэх бүтцийг бий болгох шаардлагатай байна.

Энд сум тус бүрт 3 ш шавхах насос гарган өгч, эдгээрийг хямдаар түрээслүүлэх тогтолцоог бий болгоно. Эдгээр насоснуудын ашиглалтанд тавих хяналтыг тухайн сумын худгийн сангийн хянах зүйлд оруулан сумын захиргаа хийх бөгөөд аймгийн захиргаа тогтмол хугацаанд шалгаж байна.

Хүснэгт 5.2.35 Нийт зардал (ам.доллар)

	Дундговь	Дорноговь	Өмнөговь
Сумын тоо	16	14	14
Насосны тоо	48	42	42
Нэгжийн үнэ (ам.доллар)	400	400	400
Дүн (ам.доллар)	19200	16800	16800
Нийт (ам.доллар)	52800		

(7) Худгийн эдийн засгийн үр ашгийн судалгаа

Бэлчээрийн талхлагдлыг зогсоож мал аж ахуйг тогтворжуулан, цаашдаа ашиглагдаагүй ба бага ашиглагдаж буй бэлчээрийг ашиглах замаар мал аж ахуйг өргөжүүлэхийн тулд малын усалгааны нөхцлийг сайжруулах явдал чухал. Гэхдээ худгийг ашиглалтанд оруулсны дараа тухайн худгийг ашиглаж буй хүн нь засвар үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэн хийх нь чухал. Иймээс дор дурдсан урьдчилсан нөхцлүүдэд үндэслэн худаг гаргасны дараах ашиглалт, засвар үйлчилгээний зардал болон худаг ашигласнаар гарсан үр дүнд дүн шинжилгээ хийж, малчид худгийн ашгийг бодитоор мэдэрч, засвар үйлчилгээг тасралтгүй үргэлжлүүлэн хийхэд шаардлагатай нөхцлүүдийг нэг бүрчлэн судлана.

1) Судлах нөхцлүүд

i) Загвар малчдын бүлэг

Эдийн засгийн үр ашгийг судлахын хамт загвар малчдын бүлгийг дор дурдсаны дагуу байгуулна.

2 хот айл (5 өрх айл) одоогийн байдлаар хонин толгойд шилжүүлснээр 2000 толгой малтай. Энэ бүлэг нь мал аж ахуй эрхлэлтийг тогтвортой байлгах явдлыг зорилгоо болгон өрөмдмөл худаг ашиглаж эхлэнэ.

ii) Малын тоо

Төсөл хэрэгжихээс өмнө (Without Project Case) 2000 толгой малаас дээш тооны мал хариулах боломжгүй байсан бөгөөд төслийн шугамаар худаг гаргах, сэргээн засварласны (With Project Case) үр дүнд усалгаа сайжирч (Гар худгийн усалгааны коэффициент 0.8 → Өрөмдмөл худгийн коэффициент 1.0) 2500 толгой мал хариулах боломжтой болсон.

Мөн малын тоо толгойн өсөлтийг 1994 оноос хойшхи малын тоо толгойн өөрчлөлтийг авч үзсэний үндсэн дээр 30% байна гэж үзнэ. Түүнчлэн өрхийн жилийн хэрэгцээг 100 толгой гэж үзэн үлдсэн хариулах боломжтой тоо толгойноос хэтэрсэн малыг зарна. Гэхдээ төсөл хэрэгжиж эхэлсэн эхний үед, юуны өмнө малын тоо толгойг нэмэгдүүлэх шаардлагатай тул аль болох цөөн мал зарна.

iii) Худаг гаргасны үр ашиг

Худаг гаргаснаар гарах үр дүн нь 1) Ашиглагддаггүй ба бага ашиглагддаг бэлчээрийг ашиглан малын тоо толгойг өсгөх 2) Малын усалгааг найдвартай болгох 3) Малын жинг нэмэгдүүлэх 4) Малчдын ажлыг хөнгөвчлөх 5) Дээр дурдсан үр дүнгүүд гарснаар эрсдэл багасах зэрэг болно. Эдгээрийн дотроос тоогоор илэрхийлэхэд хялбар 1) - д дурдагдсан малын тоо толгойн өсөлт 3) - т дурдагдсан малын жингийн өсөлтийг судална.

Тодорхой хэлбэл ашиг нь мал аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулсны орлого болон малын худалдаанаас орох орлогоос бүрдэнэ. Ашгийг тооцохдоо малын үнийг тухайн суманд мал худалдаалагдаж буй бодит үнээр буюу 2003 оны Дорноговь аймгийнхаар, малын төрлийн харьцааг Дорноговь аймгийн 2003 оны дундаж харьцаагаар авсан болно.

Хүснэгт 5.2.36 Малын бодит тоо болон хонин толгойд шилжүүлсэн тоо

Малын төрөл	Аймгийн дундаж харьцаа	Хонин толгойд шилжүүлэх итгэлцүүр	Шилжүүлсний дараах харьцаа	1000 хонин толгойд ногдох харьцаа	1000 хонин толгойтой тэнцэх малын тоо
Тэмээ	3.5	5	17.50	98	20
Адуу	9.3	6	55.80	311	52
Үхэр	4.6	6	27.60	154	26
Хонь	39.6	1	39.60	221	221
Ямаа	42.9	0.9	38.61	216	240
Нийт				1000	559

iv) Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг тодорхойлох

Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлогыг Дорноговь аймагт хэрэгжүүлсэн хөдөөгийн сумын судалгааны дүгнэлтэнд үндэслэн эзэмшиж буй нийт малын үнэлэгдсэн үнийн 15 % -тай тэнцүү гэж тооцно. Мөн төсөл хэрэгжсэнээр мал аж ахуйн бүтээгдэхүүний нэмүү өртгийн өсөлт 3% болно гэж үзэв.

Эндээс одоо (Төсөл хэрэгжихээс өмнө) нэг хонин толгойд ногдож буй мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлого нь 2,335 төгрөг болж байгаа бөгөөд төсөл хэрэгжсэний дараа 2405 төгрөг болно.

Хүснэгт 5.2.37 Мал аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын орлого

	1000 хонин толгойтой тэнцэх малын тоо	Үнэлэгдсэн үнэ (төгрөг)	Нийт үнэлэгдсэн үнэ (төгрөг)	МАН-н бүтээгдэхүүний борлуулалтын орлого (төгрөг)
Тэмээ	20	150,000	3,000,000	15%
Адуу	52	40,000	2,080,000	
Үхэр	26	80,000	2,080,000	
Хонь	221	25,000	5,525,000	
Ямаа	240	12,000	2,880,000	
Нийт	559		15,565,000	2,334,750

Одоогийн байдлаар 1 хонин толгойд ногдох МАА-н бүтээгдэхүүний борлуулалтын орлого : 2,335 төгрөг

Төсөл хэрэгжсэний дараа 1 хонин толгойд ногдох МАА-н бүтээгдэхүүний борлуулалтын орлого : 2,405 төгрөг

Малын тоо өссөнөөр нэмэгдэх МАА-н бүтээгдэхүүний борлуулалтын орлогын ихэнх нь ноолуурын борлуулалт нэмэгдсэнээс орох орлого юм. Иймээс өссөн мал доторхи ямааны тооноос ноолуурын борлуулалт хэдий чинээ нэмэгдсэнийг тооцоолно.

Нэмэгдсэн ноолуурын борлуулалт - 1 хонин толгойд шилжүүлж тооцсноор : 1,872 төгрөг

v) Мал худалдсан тохиолдолд олох орлогыг тодорхойлох

Орон нутгийн бэлчээрийн даацаас хэтэрсэн малыг бүгдийг зарна гэж үзэн орлогыг тооцоолно. Худалдах нэгж үнийг дээр үзүүлсэн малын үнэлэгдсэн үнэтэй адил гэж үзэн мөн дээр дурдсан МАА-н бүтээгдэхүүний борлуулалтын орлоготой давхардуулахгүйн тулд 30% багасган авч үзнэ. Эндээс одоогийн байдлаар 1 хонин толгойд шилжүүлэн тооцоолсон борлуулалтын орлого нь 10,896 төгрөг болно.

Малын худалдсан тохиолдолд олох орлогыг 1 хонин толгойд шилжүүлбэл : 10,896 төгрөг болно.

vi) Малын жин нэмэгдсэнээс гарах үр дүн

Таван хошуу малын дотроос хонь, үхрийг зарахдаа жингийн нэмэгдлийг төсөл хэрэгжүүлснээр гарах үр дүн болгон тооцно. Усалгаа болон бэлчээр сайжирснаар нэмэгдэх жингийн хэмжээг 3%, 1 кг - ийн үнийг 1,000 төгрөг, хонины нэг гулууз махны дундаж жинг 19 кг (амьдын жингийн 42%) гэж үзэн үхрийн гулууз махны жинг үүнээс 6 дахин их гэж үзье. Дээрх нөхцлүүдээр малын жин нэмэгдсэнээс гарах үр дүнг тооцоолбол төсөл хэрэгжсэний дараа малын худалдаанаас орох орлого 11,046 төгрөг болно.

Хүснэгт 5.2.38 Малын жин нэмэгдсэнээс гарах үр дүн
(хонин толгойд шилжүүлэн 2000 толгой гэж үзсэн тохиолдолд)

	1000 хонин толгойтой тэнцэх малын тоо	Зарах үнэ(Төг)	Нэмэгдсэн жин		Засагдсан үнэ (Төг)	1000 хонин толгой Нийт борлуулалтын орлого (Төг)	1 хонинд ногдох худалдааны орлого – амьдын жингээр(Төг)
			(кг)	(Төг)			
Тэмээ	20	150,000			150,000	3,000,000	Давхардуулах - гүйн тулд бууруулах хувь 70%
Адуу	52	40,000			40,000	2,080,000	
Үхэр	26	80,000	3.42	3420	83,420	2,168,920	
Хонь	221	25,000	0.57	570	25,570	5,850,970	
Ямаа	240	12,000			12,000	2,880,000	
Нийт	559					15,779,890	11,046

Төсөл хэрэгжсэний дараа малын худалдаанаас орох орлого 1 хонин толгойд шилжүүлснээр : 11,046 төгрөг.

vii) Үйлдвэрлэлийн зардал

Малчин өрхөд загвар болгон авах үйлдвэрлэлийн зардлыг эзэмшиж буй малынх нь тоо толгойноос нь хамааруулан судалсан судалгааны дүнг 5.3.39 дугаар хүснэгтэд үзүүлэв. 1 толгой малд ногдох үйлдвэрлэлийн зардлыг 1,400 төгрөг (хонин толгойд шилжүүлбэл 700 төг) гэж тооцсон. Мөн төсөл хэрэгжсэнээр малын тоо нэмэгдэх учир 1 толгой малд ногдох үйлдвэрлэлийн зардал буурна. Энэ бууралтыг 5% гэж тооцвол төсөл хэрэгжсэний дараах үйлдвэрлэлийн зардал 665 төгрөг болно.

Хүснэгт 5.2.39
Үйлвэрлэлийн дундаж зардал (Төг)

Төрөл	100 малтай өрх	200 малтай өрх
Татвар	7,760	21,750
Тэжээл	26,390	48,750
Нүүдэл	60,000	84,000
Мал эмнэлгийн үйлчилгээ	45,880	84,750
Түлш	0	30,000
Нийт	140,030	269,250
Өртөг/толгой	1,400	1,346

2) Худаг барьснаар гарах үр ашиг

Дээрх тооцооноос орлого зардлыг тооцоолон тэдгээрийн зөрүүг төсөл хэрэгжсэний үр дүн=үр ашиг гэж үзэв. Энэ үр ашиг нь 2 дахь жилээс гарч ирэх бөгөөд нэмэгдсэн дүнгээрээ 3 дахь жилээс нэмэх гарна.

Хүснэгт 5.2.40 Төслийн үр ашиг (төг)

	1 дэх жил	2 дахь жил	3 дахь жил	4 дахь жил	5 дахь жил
Нэг жилд гарах үр ашиг	-1,478,000	107,000	4,618,000	4,618,000	4,618,000
Нийт үр ашиг	-1,478,000	-1,371,000	3,247,000	7,865,000	12,483,000
	6 дахь жил	7 дахь жил	8 дахь жил	9 дахь жил	10 дахь жил
Нэг жилд гарах үр ашиг	4,618,000	4,618,000	4,618,000	4,618,000	4,618,000
Нийт үр ашиг	17,101,000	21,719,000	26,337,000	30,955,000	35,573,000

3) Худаг барих, засвар үйлчилгээ хийх, ашиглалт явуулах зардал

i) Худаг барих зардал

Худаг барих бодит зардал нь худаг тус бүрт ялгаатай боловч одоогийн байдлаар малчдын хариуцаж гаргах мөнгөний хэмжээ нь худаг шинээр гаргахад ч сэргээн засварлахад ч бараг адил байхаар журамд заасан. Иймээс худаг барих зардлын нэг хэсэг болох 500,000 төгрөгийг малчдын бүлэг эхний жил төлж барагдуулна.

ii) Тоног төхөөрөмж болон засвар үйлчилгээний зардал

Тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг мотор 5 жил, насос 10 жил гэж тогтон, моторт 600,000 төгрөг (500 ам.доллар), насосонд 1,200,000 төгрөгийг (1000 ам.доллар) шинээр худалдан авах зардал болгон тооцно. Хамгийн анх гарах тоног төхөөрөмжийн зардлыг төслөөс гаргахаар тогтсон. Тоног

төхөөрөмжийн зардлын нийт дүнгийн 3% - г засвар үйлчилгээний зардал болгон жил бүр тооцож явна.

4) Ашиглалтын зардал болон усны ундарганы хэмжээний хамаарал

Ашиглалтын зардлыг худгийн ундарганы хэмжээнээс хамааруулан тооцон гаргаж ; усны ундарганы хэмжээ болон эдийн засгийн үр ашгийн хамаарлыг тогтоосон. Малд шаардлагатай усны хэмжээг 1 хонинд 5 л/өдөр гэж тооцсон. Энэ хэмжээний усыг татахын тулд насосны ажиллах цагийг худгийн ундарганаас эргүүлэн бодож моторын ажиллах цагийг тооцоолон гаргаж ашиглалтын зардлыг олсон.

Түлшний зардал 800 төг/л, түлшний зарцуулалт 1.0 л/с, насосыг жилд 105 өдөр ажиллана гэж тооцов.

5) Ундаргын хэмжээ болон орлого зарлагын хамаарал

Дээр дурдсан нөхцлүүдээр худгийн ундарга болон үр ашгийн хамаарлыг тогтоосон. Ямар ч ундарга сайтай худаг байсан 2 жил зарлага нь ашиг орлогоосоо давсан үр дүнтэй байна. Мөн 0.3 л/с ундаргатай байх тохиолдолд нэмэгдсэн дүнгээр 3 жил хүртэл ашиг, алдагдлын тооцоо хасах дүнтэй гарна.

Хүснэгт 5.2.41 Худгийн ундарганы хэмжээ болон үр ашгийн хамаарал
(Жил тус бүрээр)(Нэгж 1000 төг)

Худгийн усалгааны чадвар (л/с)	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	6 жил	7 жил	8 жил	9 жил	10 жил
0.3	-3,007	-1,048	3,336	3,336	2,736	3,336	3,336	3,336	3,336	1,536
0.4	-2,755	-764	3,652	3,652	3,052	3,652	3,652	3,652	3,652	1,852
0.5	-2,602	-594	3,841	3,841	3,241	3,841	3,841	3,841	3,841	2,041
0.6	-2,502	-480	3,968	3,968	3,368	3,968	3,968	3,968	3,968	2,168
0.7	-2,429	-398	4,058	4,058	3,458	4,058	4,058	4,058	4,058	2,258
0.8	-2,375	-338	4,126	4,126	3,526	4,126	4,126	4,126	4,126	2,326
0.9	-2,333	-290	4,178	4,178	3,578	4,178	4,178	4,178	4,178	2,378
1.0	-2,299	-252	4,221	4,221	3,621	4,221	4,221	4,221	4,221	2,421

Хүснэгт 5.2.42 Худгийн ундарганы хэмжээ болон үр ашгийн хамаарал
(Нэмэгдсэн дүнгээр)(Нэгж 1000 төг)

Худгийн усалгааны чадвар (л/с)	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	6 жил	7 жил	8 жил	9 жил	10 жил
0.3	-3,007	-4,055	-719	2,617	5,353	8,689	12,025	15,361	18,697	20,233
0.4	-2,755	-3,519	133	3,785	6,837	10,489	14,141	17,793	21,445	23,297
0.5	-2,602	-3,196	645	4,486	7,727	11,568	15,409	19,250	23,091	25,132
0.6	-2,502	-2,982	986	4,954	8,322	12,290	16,258	20,226	24,194	26,362
0.7	-2,429	-2,827	1,231	5,289	8,747	12,805	16,863	20,921	24,979	27,237
0.8	-2,375	-2,713	1,413	5,539	9,065	13,191	17,317	21,443	25,569	27,895
0.9	-2,333	-2,623	1,555	5,733	9,311	13,489	17,667	21,845	26,023	28,401
1.0	-2,299	-2,551	1,670	5,891	9,512	13,733	17,954	22,175	26,396	28,817

б) Зудын эрсдэлийг бодолцсон тооцоо

Дээрх тооцоон дээр нэмж зудын хохирлыг багасгаж тооцон тусад нь авч үзсэн тооцоог хийв.

Энд урьдчилсан нөхцөл болгон одоогийн байдлаар 5 жилд нэг удаа зудын хохирол үзэж (3 дахь, 8 дахь жил), малын тоо толгой 20% - иар буурч байгааг 10% буурна гэж үзсэн болно. Энэ тохиолдолд, 0.5 л/с- ээс дээш ундаргатай худгийн хувьд 3 дахь жилээс, түүнээс бага ундаргатай худгийн хувьд 4 дэхь жилээс ашигтай ажиллана гэсэн тооцоо гарсан.

Хүснэгт 5.2.43 Худгийн ундарга болон үр ашгийн хамаарал
(Жил тус бүрээр:Зудын хохирлыг тооцсон)(нэгж : 1000 төг)

Худгийн усалгааны чадвар (л/с)	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	6 жил	7 жил	8 жил	9 жил	10 жил
0.3	-3,007	-1,048	2,849	6,777	2,736	3,336	3,336	2,849	6,777	1,536
0.4	-2,755	-764	3,165	7,093	3,052	3,652	3,652	3,165	7,093	1,852
0.5	-2,602	-594	3,354	7,282	3,241	3,841	3,841	3,354	7,282	2,041
0.6	-2,502	-480	3,481	7,409	3,368	3,968	3,968	3,481	7,409	2,168
0.7	-2,429	-398	3,571	7,499	3,458	4,058	4,058	3,571	7,499	2,258
0.8	-2,375	-338	3,639	7,567	3,526	4,126	4,126	3,639	7,567	2,326
0.9	-2,333	-290	3,691	7,619	3,578	4,178	4,178	3,691	7,619	2,378
1.0	-2,299	-252	3,734	7,662	3,621	4,221	4,221	3,734	7,662	2,421

Хүснэгт 5.2.44 Худгийн ундарга болон үр ашгийн хамаарал
(Нэмэгдсэн дүнгээр : Зудын хохирлыг тооцсон) (Нэгж 1000 төг)

Худгийн усалгааны чадвар (л/с)	1 жил	2 жил	3 жил	4 жил	5 жил	6 жил	7 жил	8 жил	9 жил	10 жил
0.3	-3,007	-4,055	-1,206	5,571	8,307	11,643	14,979	17,828	24,605	26,141
0.4	-2,755	-3,519	-354	6,739	9,791	13,443	17,095	20,260	27,353	29,205
0.5	-2,602	-3,196	158	7,440	10,681	14,522	18,363	21,717	28,999	31,040
0.6	-2,502	-2,982	499	7,908	11,276	15,244	19,212	22,693	30,102	32,270
0.7	-2,429	-2,827	744	8,243	11,701	15,759	19,817	23,388	30,887	33,145
0.8	-2,375	-2,713	926	8,493	12,019	16,145	20,271	23,910	31,477	33,803
0.9	-2,333	-2,623	1,068	8,687	12,265	16,443	20,621	24,312	31,931	34,309
1.0	-2,299	-2,551	1,183	8,845	12,466	16,687	20,908	24,642	32,304	34,725

5.2.4 Шинээр барьсан ба сэргээн засварласан худгуудын засвар йлчилгээ

Шинээр барьсан болон сэргээн засварлагдсан худгуудын тогтвортой ажиллагааг хангахын тулд засвар үйлчилгээ явуулах тогтолцоог бий болгоход чиглэсэн дор дурдсан арга хэмжээг авах шаардлагатай.

- Эзэмшигчийн хариуцлагыг сайжруулах арга хэмжээг худаг байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хэрэгжүүлэх
- Сумын захиргаанаас худаг ашиглагчийн зүгээс хийх засвар үйлчилгээг дэмжихэд зориулж сумын худгийн санг байгуулах

- Сумын худгийн санг ашиглан сумын хэмжээнд хийгдэх тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд хяналт тавих бүтцийг бий болгох


(1) Эзэмшигчийн хариуцлагыг сайжруулах арга хэмжээг худаг байгуулалтын ажилтай зэрэгцүүлэн хэрэгжүүлэх

Эзэмшигчийн хариуцлагыг сайжруулахад чиглэсэн дараах арга хэмжээнүүдийг авна.

- Малчдыг зохион байгуулалтанд оруулна.
Худаг ашиглаж буй малчдыг зохион байгуулалтанд оруулж хамтран ашиглах бүтцийг бий болгоно.
- Худаг ашиглалтын гэрээ хийх
Худгийг ашиглалтанд оруулсны дараа малчдын бүлэгтэй сумын захиргаа гэрээ байгуулан засвар үйлчилгээний хариуцлагыг тодорхой болгоно. Энэ гэрээг сумын даргын шийдвэрт үндэслэн хийх бөгөөд бүлгийн бүтэц гишүүдийг ч гэрээний хавсралтанд тодорхой бичнэ.
- Барих зардлын эхний төлбөрийг хийх
Худаг барих хүсэлт гаргах шатанд, худаг барьж эхлэх үе шатыг 2 үе шатанд хувааж , тухайн худгийг ашиглах бүлгээс барих зардлын тодорхой хэсгийг журмын дагуу гаруулна. Эзэмшигчийн хариуцлагыг сайжруулахтай хамт , бүлгийн худаг ашиглах хүсэл бодит эсэхийг нягтлах боломжтой болно.
- Малчдын худгийн сан байгуулах
Худгийн ашиглалтыг тасралтгүй явуулахын тулд бүлэг дотроо худгийн сан байгуулна. Үүний тулд бүлгийн худгийн сангийн дансыг худаг барих хүсэлт гаргах үедээ нээх нөхцөл тавьсан.

Зохион байгуулалтад оруулах эдгээр арга хэмжээнүүдийг сумын ЗДГТ-аас малчдыг уриалан хэрэгжүүлэх юм. Малчдыг зохион байгуулалтад оруулах ажлын арга туршлага, сумын ЗДТГ-ын ажилтнуудын чадвар чухал шаардлагатай.

Худгийг ашиглалтанд өгөх хүртэлх үйл явцыг хугацааны дэс дарааллаар авч үзвэл дараахь схемд үзүүлсний дагуу байна.



Зураг 5.2.8 Худаг байгуулалтын үйл явц (Сумын ЗДТГ, малчид)

(2) Сумын худгийн сан байгуулах

Худаг ашиглалтын гэрээ нь сумын захиргаанаас малчдад худаг ашиглах эрхийг өгч засвар үйлчилгээг хариуцуулж даалгаж буй хэрэг юм. Гэхдээ ер нь бол сумын захиргаа, аймгийн захиргаанд малчдын хийх худгийн засвар үйлчилгээий ажлыг дэмжих төсөв байдаггүй.

Тоног төхөөрөмжийн эвдрэл гэмтэлд бэлтгэлтэй байх үүднээс малчдын бүлэг тус бүр сан байгуулах боловч шаардлагатай хөрөнгө хуримтлагдахаас өмнө тоног төхөөрөмж эвдэрч гэмтсэн тохиолдолд засварын зардал болон тоног төхөөрөмжийг шинэчилж солих зардлыг гаргаж чадахгүй явдал гарна. Ийм тохиолдолд сумын захиргаа малчдыг дэмжих чадвартай байхын тулд сумын захиргаанд худгийн сан байгуулна.

Малчдын бүлэг худгийн барилгын ажлын зардлаас өөрсдийн хариуцах хэсгээс арай ахиу мөнгийг сумын захиргаанд төлж, энэхүү илүү төлсөн хэсгээр нь худгийн санг байгуулах юм. Санг эхний ээлжинд сумын захиргаанаас ашиглалтад оруулсан худгийн сэлбэг материалыг худалдан авах, эвдэрсэн тоног төхөөрөмжийг засварлах хөрөнгө болгон ашиглах шаардлага гарч ирэх бөгөөд үүнд 1,000 ам.доллар орчим шаардлагатай.

Сумын худгийн сангийн ашиглалтыг ил тод байлгаж, сангийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахын тулд жилд 1 удаа сумын иргэдэд үйл ажиллагааны тайлан тавих үүрэг хүлээнэ.

1) Сумын худгийн сангийн тухай товч мэдээлэл


Зорилго : Ирээдүйд нийт сумын хэмжээнд худаг ашиглах явдлыг хөгжүүлэх

Үйл ажиллагаа : Дор дурдсан малчдын бүлгүүдэд хөрөнгийн дэмжлэг үзүүлэх

- (1) Одоо ашиглаж буй худгийн насос, мотор зэргийг засварлах болон сольж шинэчлэх
- (2) Суман дахь гар худгуудыг сэргээн засварлах болон шинээр гаргах
- (3) Суман дахь сэргээн засварлах шаардлагатай өрөмдмөл худгуудын судалгааг хийх болон тэдгээрийг сэргээн засварлах
- (4) Сумаас худаг ашиглалтанд оруулахад шаардлагатай бусад үйл ажиллагаа явуулахад

2) Хэрэгжүүлэх бүтэц

Сумын худгийн сан нь дараах бүтэц зохион байгуулалтын дагуу ажиллана.



Зураг 5.2.9 Сумын худгийн санг ашиглах бүтэц, зохион байгуулалт

(3) Худгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний тогтолцоог бий болгох

Худгийн тоног төхөөрөмж эвдэрсэн үед малчдын бүлэг засвар үйлчилгээг хийх ёстой боловч бүх л тоног төхөөрөмжийг малчид өөрсдөө худалдан авч нийлүүлэх нь хүндрэлтэй учир мэргэжилтний тусламж дэмжлэгийг авах тогтолцоо шаардлагатай.

Өнөөг хүртэл худгийг барьсан орон нутгийн худгийн компани нь үргэлжлүүлэн худгийн засвар үйлчилгээг хариуцаж ирсэн боловч, цаашид гүйцэтгэгчийг тендерээр шалгаруулдаг болгон өөрчилсөн тохиолдолд орон нутгийн гүйцэтгэгчийн оролцоо багасах магадлал өндөр.

Цаашид, малчдын бүлэг бүр худгийн засвар үйлчилгээг хариуцлагатайгаар хийж явах шаардлага гарч байна. Иймээс худгийн засвар үйлчилгээнд хяналт тавих үйл ажиллагааг сум болон аймгийн захиргааны дэмжлэгтэйгээр тасралтгүй үргэлжлүүлэн хийх бүтэц, зохион байгуулалтыг бий болгоно.

Ялангуяа моторын эвдрэл нь туршилтын төслийн явцад олон гарч байсан бөгөөд үүнтэй холбогдуулан авч байсан арга хэмжээнүүдийн үр дүнд олж авсан худгийн засвар үйлчилгээний хяналтанд шаардлагатай үйл ажиллагааг дор дурдав.

1) Малчдад тоног төхөөрөмжийн ашиглалтын талаар сургалт явуулах

Худгийг ашиглаж эхлэх үед бүлэг бүрээс 2 болон түүнээс дээш хүнийг оролцуулан тоног төхөөрөмж ашиглалтын сургалтыг явуулна. Ашиглалтын эхний үе шатанд эвдрэл олон гарч, тоног төхөөрөмжтэй харьцаж дадаагүй малчид өөрсдөө засах гэснээс улам дордуулах явдал байдгаас ашиглаж эхэлснээс хагас жилийн дараа дахин тоног төхөөрөмжийг ашиглах сургалт явуулна.

2) Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцсан хүнийг бэлтгэх

Малчид тоног төхөөрөмжийн эвдэрлийн талаар зөвлөлдөх, засварын үед тусламж авах техникийн хүн ойр байх нь тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээнд хяналт тавихад чухал. Иймээс сум бүрт тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хяналт хариуцсан нэг нэг хүн бэлдэх сургалтыг явуулна. Энэ үед тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хариуцуулах хүнийг сонгохдоо техникийн мэдлэгтэй хүнийг сонгож авах шаардлагатай.

Энэ засвар үйлчилгээ хариуцагч нь худгийн тоног төхөөрөмжийн хяналтанд гол үүрэг гүйцэтгэх учир дээрх сургалт нь маш чухал зүйл юм. Энэ сургалтыг сумын захиргаа болон аймгийн захиргааны орон нутгийн санхүүгийн эх үүсвэрийг ашиглан явуулах бөгөөд сургалтанд хамрагдагсдын хариуцлага ухамсрыг дээшлүүлэх сургалт болно.

3) Суманд сэлбэг хэрэгсэл нөөцөлж, тоног төхөөрөмж нийлүүлэх тогтолцоотой болох


Суманд түүнчлэн аймагт мотор болон бусад тоног төхөөрөмжийн сэлбэгийг худалдан авах боломжгүй бөгөөд эхний үе шатанд моторын амархан эвдэрдэг сэлбэгийг сумын захиргаа худгийн санг ашиглан нөөцөлж бэлдэнэ. Нөөцөлсөн сэлбэгийг сумын захиргаа эсвэл сум дахь засвар үйлчилгээ хариуцагч хяналт тавин малчдад зарна.

Ижил төрлийн тоног төхөөрөмжийн тоо өсвөл эдгээр сэлбэгийн нөөцийг жижиг бизнес болгон хувьчилна.


4) Орон нутгийн худгийн компанийн дэмжлэгийг авч хамтран ажиллах

Тухайн сумын захиргааны худгийн засвар үйлчилгээ хариуцсан ажилтан шийдвэрлэж чадахгүй эвдрэл гэмтлийг засах асуудлыг шийдэх, шаардлагатай тохиолдолд Улаанбаатар дахь тоног төхөөрөмжийн компанитай хэлэлцээр хийх мэргэжилтэн шаардлагатай. Засаг захиргааны хувьд бол аймгийн ХАА - н газрын усны салбар хариуцсан ажилтан тохиромжтой боловч жинхэнэ техникийн талын дэмжлэг болон гүйцэтгэгчтэй хийх гэрээ хэлэлцээр зэрэгт худгийн компани нь илүү мэргэжлийн үйлчилгээ өгөх боломжтой.

Тиймээс ажлын эсвэл тоног төхөөрөмжийн захиалга өгөхдөө орон нутгийн худгийн компанитай засвар үйлчилгээний болон хяналтын гэрээ байгуулах арга хэмжээг авч, дэмжлэг авах зохион байгуулалтыг бий болгох шаардлагатай.




Зураг 5.2.10 Худгийн төхөөрөмжийн засвар үйлчилгээ явуулах бүтэц, зохион байгуулалт



Зураг 5.2.11 Дундговь аймгийн I-р үе шатны худаг байгуулалтын төлөвлөгөө




- Тэмдэгт**
- Сумны хил
 - ▭ Төв суурин газар
 - ◻ Аймгийн төв
 - Сумын төв
 - ▬ Төмөр зам
 - Зам
 - Өрөөмөл худаг
 - Ашиглах
 - ▨ Засварлах
 - ▩ Шинээр барих
 - ▧ Засварлахгүй
 - ⊗ Уурхайн худаг
 - ▲ Ашиглах
 - ▲ Засварлах
 - ▲ Шинээр барих
 - ⊗ Засварлахгүй
 - Уурхайн худаг
 - Засварлах
 - Шинэ богино явцанг худаг
 - Шинэ гар худаг
 - Уурхайн худаг гар аргаар ашиглах
 - ⊗ Шинээр гаргахгүй
 - ⊕ Гар худаг
 - ┌ Булаг шанд
 - Нуур
 - Шинээр гаргах худаг
 - ★ Богино явцанг худаг
 - ┌ Гар худаг
 - Тогтвортой усжуулагдсан бэлчээр
 - ▨ Зам тойрог
 - ▨ 3-5 км тойрог



Зургаг 5.2.12 Дорноговь аймгийн 1-р үе шатны худаг байгуулалтын төлөвлөгөө

Тэмдэг

<ul style="list-style-type: none"> □ Суурийн хий □ Тов суурийн газар □ Аймгийн төв □ Сумын төв — Төмөр зам — Зам 	<ul style="list-style-type: none"> ■ Оролцмал худаг ■ Ашиглах ■ жонд засварлах □ Засварлах ■ Шинээр барих □ Байдал төлөрхөйгүй ■ Шаардлагагүй ■ Засварлахгүй 	<ul style="list-style-type: none"> ▲ Богино яндант худаг ▲ Ашиглах ● Засварлах ▲ Шинээр барих × Засварлахгүй 	<ul style="list-style-type: none"> ● Уургалин худаг ● Засварласан ● жонд засварлах ○ Засварлах ⊗ Шинэ богино яндант худаг ⊕ Шинэ гар худаг ○ Уурхайн худаг гар аргаар ашиглах 	<ul style="list-style-type: none"> ■ Шинээр гаргах худаг ■ Оролцмол худаг, Өндөр боломжтой ■ Оролцмол худаг, Боломжтой ■ Оролцмол худаг, Төлөрхөнгүй ● Богино яндант худаг, Боломжтой ● Богино яндант худаг, Төдөрхөйгүй ◆ Гар худаг, Боломжтой 	<ul style="list-style-type: none"> ◆ Гар худаг Г Булаг шанд ★ Нуур □ Тусгай хамгаалттай газар □ Тогтвортой үежүүлэгдсэн бэлчээр ■ Зам тойрог ▨ 3-5 км тойрог
--	--	---	--	--	---



Зураг 5.2.13 Өмнөговь аймгийн 1-р үе шатны худаг байгуулалтын төлөвлөгөө

- Тэмдэг**
- Сумын хил
 - Settlements
 - Аймгийн төв
 - Сумын төв
 - Зам
 - Тусгай хамгаалттай газар
 - Дархан цаазат газар
 - Тусгай хамгаалттай газар
- Өрөмдмэл худаг**
- Ашиглах
 - Засварлах
 - Шинээр барих
 - Засварлахгүй
 - Богшино явцтай худаг
 - Ашиглах
 - Засварлах
 - Шинээр барих
 - Засварлахгүй
- Уурхайн худаг**
- Засварлах
 - Шинэ богшино явцтай худаг
 - Шинэ гар худаг
 - Уурхайн худаг гэр эргээр ашиглах
 - Шинээр гаргахгүй
 - Шинээр гаргах худаг
 - Өрөмдмөл худаг
 - Богшино явцтай худаг
 - Гар худаг
 - Гар худаг
 - Булаг шанд
 - Нуур
- Тогтвортой усжуулалттай болгосор**
- Зам тойрог
 - 3-5 км тойрог

5.3 Мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах тухай бүрэлдэхүүн хэсэг

Малын аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулах тухай хэсэг нь 1. Шилмэл омог, үүлдрийн мал үржүүлэх төсөл, 2. Мал аж ахуйн эрхлэлтийн менежментийг сайжруулах төсөл, 3. Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээл, ханган нийлүүлэлтийг сайжруулах төсөл, 4. Эрсдэлийн менежментийн чадварыг дээшлүүлэх төсөл гэсэн 4 төслөөс бүрдэнэ. Энэхүү бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулж, найдвартай ажиллагааг нь хангахад шаардагдах арга хэмжээ, үйл ажиллагаагаар дамжуулан, хөдөөгийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг бодит зүйл болгоход оршино.

Эдгээр төслүүдийг орон нутгийн засаг захиргаа удирдан хэрэгжүүлэх юм.

5.3.1 Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах төсөл

(1) Төслийн ерөнхий агууламж

Зах зээлийн эдийн засагт шилжсэний дараа мал эмнэлгүүд хувьчлагдаж үйлчилгээ нь төлбөртэйгээр хийгдэх болсноор малчид мал эмнэлгийн үйлчилгээнээс холдов. Мал эмнэлгийн байгууллагуудын үйл ажиллагаа тогтворгүй болж улмаар мал эмнэлгүүд цөөрч, эм тариа нь ховордон, мал эмнэлгийн арга ажиллагаа чанаргүйжжээ. Ийнхүү малчид малаа эрүүл байлгах боломжгүй байдалд ороод байна. Энэ нөхцөл байдлыг сайжруулснаар малын эрүүл мэндийг сайжруулж улмаар мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг тогтворжуулах боломжтой юм.

Тэрчлэн хувьчлагдсан мал эмнэлгүүд мал эмнэлгийн менежментэд суралцах шаардлагатай бөгөөд энэ чиглэлийн сургалтуудыг төслийн хүрээнд зохион байгуулах болно. Түүний зэрэгцээгээр малчид мал эмнэлгийн байгууллагатай гэрээ байгуулан тогтвортой ажиллах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

(2) Хамрагдах хэсэг болон Хэрэгжүүлэгч байгууллага

Хамрагдах хэсэг: Мал эмнэлэг ба малчдын бүлэг

Хэрэгжүүлэгч байгууллага: Сум болон аймгийн удирдах байгууллагууд

(3) Зорилт

1) Төслийн зорилт

Хөдөө орон нутаг дахь мал сүргийн эрүүл мэнд хамгаалагдана.

2) Эрхэм зорилт

Малчид ба мал эмнэлгүүд малын өвчин эмгэг, паразиттай холбоотой өвчний асуудлыг өөрсдийн хүрээнд бүрэн шийдвэрлэх чадвартай болох.

(4) Гарах дүн

1) Орон нутаг дахь мал эмнэлгийн үйлчилгээний чанар сайжирна.

Мал эмнэлгийн арга ажиллагааг сайжруулах сургалтууд болон аж ахуйн нэгж, байгууллагын менежментийн сургалтуудыг орон нутагт явуулна.

Мөн сумын мал эмнэлэгт материал, тоног төхөөрөмж, малын халдварт өвчнөөс хамгаалах хэрэгсэл нийлүүлэгдэнэ. Багаж, материалыг өмчлөгчийн сэтгэлгээгээр ашиглуулах үүднээс тухайн мал эмнэлгээр зардлын тодорхой хэсгийг хариуцуулна.

2) Малчид болон мал эмнэлгийн хооронд хамтран ажиллах тогтолцоо бий болно. (Малчдын бүлэг байгуулагдана)

Аймаг болон сумын захиргааны удирдлагаар малчид бүлэг байгуулж, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх тухай гэрээг мал эмнэлэгтэй байгуулна. Гэрээний дагуу малчдын бүлгүүд мал эмнэлгүүдтэй харилцан ажиллана. Мөн янз бүрийн өвчний урьдчилан сэргийлэх тарилга, халдваргүйжүүлэлт зэрэг мал эмнэлгийн үйлчилгээний үнэ тариф, төлбөрийн арга хэлбэрийг тус гэрээнд маш тодорхой тусгана.

3) Орон нутагт мал эмчилгээний бүтээгдэхүүн тогтвортой нийлүүлэгдэнэ.

ТББ буюу сумын ЗДТГ нь эрэлт хэрэгцээ ихтэй эм тариаг худалдан авахад шаардлагатай эргэлтийн хөрөнгийг бүрдүүлж, мал эмнэлэгтэй хамтран эм тарианы нөөцийг бий болгоно. Малчид хэрэглэсэн эмийн бүтээгдэхүүнийхээ үнийг төлөх ба мал эмнэлэг нь эм тарианы зарцуулалтыг хариуцан малчдаас орж ирсэн төлбөрөөс бүрдэх эргэлтийн санг удирдан ажиллуулна.

4) Малчид малын эрүүл мэнд, эрүүл ахуйн тухай анхан шатны мэдлэгтэй болно.

Мал эмнэлгийн үйлчилгээ төлбөртэй байдаг гэдгийг малчид мэддэг хэдий ч үүнийг нийгмийн төрөл бүрийн үйлчилгээнүүдийн нэг гэдгийг тайлбарлаж төлбөрт суурилсан үйлчилгээг ойлгуулах нь чухал болно. Малчид малын эрүүл мэнд, эрүүл ахуйн тухай шаардлагатай мэдлэг, вакцинд хамруулах шаардлагатай хугацаа мөн малынхаа чанарыг муутгахгүйн тулд юу хийвэл зохих талаарх мэдлэгт суралцана. Тэрчлэн мал эмнэлгийн үйлчилгээ хүрдэггүй алслагдсан нутгийн малчдад малын үндсэн өвчнүүдийг бие даан оношлох, эмчлэх чадварыг олгох нь чухал юм. Иймд малчдын төлөөлөгчдийг хамруулсан эрчимжсэн сургалтыг зохион байгуулна.

(5) Хөрөнгө оруулалт

Мал эмнэлгийн сургалт (мал эмнэлгийн технологи, менежментийн чадавхийн сургалт), малчдад зориулсан сургалт (өвчний тухай мэдлэг, анхан шатны тусламж, эмчилгээ), малын эм (эмийн нөөц буй болгох, эмийн эргэлтийн хөрөнгийн эх

үүсвэр болгох), сумын мал эмнэлгийн багаж, төхөөрөмж (мал эмнэлэг зардлын тодорхой хэсгийг хариуцна)

(б) Төслийг хэрэгжүүлэхэд анхаарах зүйл, ажил үүргийн хуваарь

Мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангахад үндсэн суурь дэвсгэр болсон бэлчээр, уснаас гадна малын эрүүл ахуйн асуудал чухлаар тавигдана. Иймд мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах асуудал нь Монгол улсын мал аж ахуйн тогтолцоог боловсронгуй болгох зорилтыг биелүүлэх үүднээс зайлшгүй шийдвэрлэвэл зохих бүрэлдэхүүн хэсэг юм.

Энэ төслийг хэрэгжүүлэх хүрээнд мал эмнэлгийн байгууллагууд болон малчдыг зохион байгуулалтанд оруулахаас гадна эм тарианы санг байгуулах ажлыг төлөвлөж байна. Үүний тулд малчдыг зохион байгуулалтанд оруулах арга хэлбэр, сангийн ашиглалтын ил тод байдлыг хангасан ойлгомжтой, тодорхой дүрэм, журмыг боловсруулан, малчид болон зохион байгуулалтанд орсон бүлгийн гишүүд бүх төрлийн мэдээллийг авах боломжийг бүрдүүлэх нь зайлшгүй нөхцөл болон тавигдах юм. Тэрчлэн мэдлэг, чадвар дутагдаж буй мал эмнэлгийн байгууллагуудын менежментийн арга барил, гэрээ хэлэлцээр байгуулах чадварыг дээшлүүлэхийн тулд зөвхөн технологийн зорилтоор хязгаарлагдалгүй зохион байгуулалт болон ня-бо бүртгэлийн сургалт явуулах зэрэг арга хэмжээ авах нь чухал юм.

Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах төслийг доор дурьдсан хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтыг бий болгож, оролцогч тус бүрийн ажил үүргийн хуваарийг тодорхой болгох үндсэн дээр хэрэгжүүлэх шаардлагатай. Богино хугацааны зорилтын хүрээнд боловсон хүчнийг бэлтгэх асуудлыг голлон анхаарч, түүний дараа урт хугацааны зорилтын хүрээнд шаардлагатай орчинг бий болгох асуудлыг шийдвэрлэнэ. Оролцогч талуудын ажил үүргийн хуваарийг дараахь хүснэгтэд харуулав.

Хүснэгт 5.3.1 Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах төсөлд оролцогчдын ажил үүргийн хуваарь.

Хэрэгжүүлэх байгууллага	Үйл ажиллагаа
Засгийн газар (ХХААЯ)	<ul style="list-style-type: none"> Малын эмч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөр, мал эмнэлгийн менежментийн хөтөлбөр боловсруулан, хөрөнгө төсөвлөх Малчдад чиглэсэн малын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл ахуйн нөхцлийг сайжруулах кампанит ажлын хөрөнгийг төсөвлөн, хэрэгжүүлэх Мал эмнэлгийн материал, тоног төхөөрөмжийн тусалцаа үзүүлэхэд зориулсан төсөв гаргаж, хуваарилах. Малын эм тарианы хангамж, нийлүүлэлтийн найдвартай тогтолцоог бий болгох
Аймаг (ЗДТГ)	<ul style="list-style-type: none"> Сургалт (менежмент ба технологийн) явуулах. Алслагдсан нутгийн малчдыг сургалтанд хамруулах
Сумын ЗДТГ	<ul style="list-style-type: none"> Мал эмнэлгийн байгууллагуудыг зохион байгуулалтанд оруулах Малчдын бүлэг байгуулах (Эм тарианы сан байгуулах) Улсын дэмжлэгтэйгээр мал эмнэлгийн зориулалтын багаж, төхөөрөмжийн тусламж, дэмжлэг авах, хөнгөлөлттэй зээлд хамрагдах
Мал эмнэлгийн байгууллага.	<ul style="list-style-type: none"> Мал эмнэлгийн зохион байгуулалт, менежментийн сургалтанд хамрагдах. Арга технологио дээшлүүлэх Эмчилгээний байгууламж, багаж, төхөөрөмж, материал хангамжийн байдлыг сайжруулах